

Ж.Батсайхан

**ТӨРӨӨС МӨНГӨНИЙ  
БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД  
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

*Иргэдэд зориулав.*

*Арга зүйн хялбаршуулсан  
танилцуулга*

Улаанбаатар хот  
2015 он



Монгол Улсын Их Хурал “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр баталлаа.

Төрөөс 2015 онд баримтлах мөнгөний бодлого нь эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй, тогтвортой өсөх орчинг бүрдүүлэхэд чиглэгдэж байна.

Мөнгөний бодлогын үр нөлөө нь экспорт болон гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар гадаад валютын орох урсгал, төлбөрийн тэнцлийг эрс сайжруулж улсын төсөв, санхүүгийн зохистой бодлого хэрэгжүүлэх талаарх Засгийн газрын бодлого, идэвхтэй үйл ажиллагаатай шууд хамааралтай байх болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ГАРАМГАЙБААТАР



Эрхэм уншигч Таны амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл” – ийн хялбаршуулсан товхимлыг 3 дахь жилдээ эрхлэн гаргаж байна. Энэ нь төрийн мөнгөний бодлого, хэрэгжилтийг иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэхэд чухлаар нөлөөлж байдаг билээ.

Монгол Улсын эдийн засаг сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд уул уурхай хэмээх хэлбэлзэл ихтэй, мөчлөгийн шинжтэй салбараас үлэмж хамааралтай болсны зэрэгцээ Монгол Улс хуримтлал буюу бэрх цаг үе ирэхэд түүнийг даван гарах үүцээ бэлдэж чадаагүй ирсэн нь 2012 оны сүүлийн хагасаас эхэлсэн төлбөрийн тэнцлийн хүндрэл 2013 онд хямралын шинжтэй болоход, улмаар түүний сөрөг нөлөөлөл нь 2014 оны туршид үргэлжилж, эдийн засгийн хүндрэл үүссэний суурь шалтгаан байсан юм. Иймд Монголбанк сүүлийн хоёр жилийн туршид төлбөрийн тэнцлийн хямралыг санхүүгийн болон эдийн засгийн хямрал болгохгүй байх, нийт эдийн засгийг агшуулахгүй байлгах, улмаар макро эдийн засаг, санхүүгийн салбарыг бүхэлд нь тогтворжуулахад төрийн мөнгөний бодлогыг чиглүүлэн ажиллалаа.

2015 онд мөнгөний бодлогын үндсэн зорилт нь макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг дунд хугацааны зорилтот түвшин болох 7 хувьд байлгах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд тус тус чиглэхээр Монгол Улсын Их Хурлаас баталсан нь макро эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалж, улмаар дунд, урт хугацаанд эдийн засаг тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчныг бүрдүүлэхэд чиглэж байгаа болно.

Энэхүү товхимол нь мөнгөний бодлогын үндсэн зорилт, түүнд хүрэх арга хэмжээ, бодлогын хэрэгслүүд, хэрэгжилтийн үр нөлөөллийг танин мэдэхэд тань чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ



## **ТОВХИМОЛООС ЮУ МЭДЭЖ БОЛОХ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ТУХАЙ**

**Оршил хэсэг** нь анх удаа төрийн мөнгөний бодлоготой танилцаж байгаа хүмүүст зориулагдсан бөгөөд энэ хэсгээс мөнгө, банк яагаад хэрэгтэй байдаг, мөнгөний бодлого гэж юуг хэлээд байгаа талаар хэн боловч мэдвэл зохих ойлголтыг авах болно.

**Нэгдүгээр хэсэг** нь төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийг хялбаршуулсан хэлбэрээр танилцуулахад чиглэгдсэн бөгөөд энэ хэсгээс төрийн мөнгөний бодлогыг төлөвлөхөд хэрэглэгддэг гол гол үзүүлэлтүүд, тэдгээрийн тодорхойлолт, тооцооны зарим аргачлал, 2015 онд мөнгөний бодлогын талаар тавьж байгаа зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, түүнчлэн мөнгөний бодлогын 2014 оны урьдчилсан гүйцэтгэлийн явц, байдлын талаар товч ойлголт авах боломжтой.

**Хоёрдугаар хэсэгт** Улсын Их Хурлын тогтоол шаардлагатай зарим албан мэдээллийг орууллаа.

Товхимолын хэсэг тус бүрийн агуулгын задаргааг нарийвчлан дугаарласан (1.1.1 гэх мэт) нь сонирхсон зүйлтэйгээ хэсэгчлэн танилцах боломжийг олгоно. Үндсэн чиглэлтэй “зорилт–арга хэмжээ–урьдчилсан гүйцэтгэл” гэсэн дарааллаар танилцах боломжтой.

Мөнгөний бодлогын зарим гол үзүүлэлтүүд, тэдгээрийн нэр томъёоны тодорхойлолт, тооцооны зарим аргачлалын талаар товч ойлголт өгөх үүднээс тусгайлан хайрцагласан “тодруулга”-ыг хийж өгөв.

Товхимолд тусгагдсан зорилт, арга хэмжээ, тоо баримт нь “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2014 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоол, Монголбанкны Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн 2015 оны үндсэн чиглэл батлах тухай тогтоолын төсөл, түүний танилцуулга, хавсралт тооцоо, тоо баримтаас эх сурвалжтай болно.

Боловсруулж, хэвлэлд бэлтгэсэн  
багийн гишүүд


## АГУУЛГА

<b>ОРШИЛ ХЭСЭГ. БАНК, МӨНГӨНИЙ ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД</b>	6
<b>НЭГ. МӨНГӨ БА БАНК</b>	7
<b>ХОЁР. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТУХАЙ ТОЙМ ОЙЛГОЛТ</b>	13
<b>I ХЭСЭГ. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ</b>	16
<b>1.1. 2015 оны мөнгөний бодлогын гол агуулга</b>	17
1.1.1. Макро эдийн засгийн тогтвортой байдалд мөнгөний бодлогын үзүүлэх нөлөөлөл	18
1.1.2. Санхүүгийн салбарын тогтвортой байдалд мөнгөний бодлогын үзүүлэх нөлөөлөл	21
<b>1.2. 2015 оны мөнгөний бодлогын үндсэн зорилтууд</b>	22
1.2.1. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд тавигдах зорилт, арга хэмжээ	23
1.2.1а. Инфляцийн түвшин	25
1.2.1б. Төгрөгийн ханш, түүний төлөв, байдал	33
1.2.2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд тавигдах зорилт, арга хэмжээ	39
1.2.2а. Банкуудын эрсдэл даах чадварын дээшлэлт	40
1.2.2б. Банкны хяналт, шалгалт	45
1.2.3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд тавигдах зорилт, арга хэмжээ	50
1.2.3а. Төлбөр тооцооны системийн хөгжил	51
1.2.3б. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ, харилцагчдын санхүүгийн боловсрол	54
1.2.3в. Мөнгөний бодлогын ил тод байдал	57
<b>II ХЭСЭГ. АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД</b>	61
<b>2.1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах         үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын 2014 оны         11 дүгээр сарын 13-ны өдрийн 69 дүгээр тогтоол</b>	62
<b>2.2. Мөнгөний үзүүлэлтүүд: 2008–2015 он</b>	67



# ОРШИЛ ХЭСЭГ

## БАНК, МӨНГӨНИЙ ТАЛААРХ ҮНДСЭН ОЙЛГОЛТУУД



Энэ хэсгээс:

Мөнгө ба банкны талаарх тулгуур ойлголтын хүрээнд:

- Мөнгө гэж юу болох, хэрхэн үүссэн
- Банк яаж мөнгийг үржүүлдэг
- Төв банк, түүний үүрэг
- Төв банкны бодлогын арга хэрэгслүүд, тэдгээрийн агуулга

Мөнгөний бодлогын талаарх тойм ойлголтын хүрээнд:

- Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн ерөн хий агуулга, зарчим
- Эдийн засаг дахь мөнгөний хэмжээнд нөлөөлөх арга хэрэгслүүдийн тухай ерөнхий мэдлэгтэй болж улмаар төрөөс мөнгөний бодлогын талаар жил бүр баримтлах үндсэн чиглэлийг боловсруулах, хэлэлцэх, батлах, гүйцэтгэлийг хангахад санаа бодлоо илэрхийлж байх боломжийг олно.

## **НЭГ. МӨНГӨ БА БАНК**

### **А. МӨНГӨ ГЭЖ ЮУ ВЭ, ЯАЖ ҮҮССЭН БЭ?**

Бараа үйлчилгээ, эд баялгын оронд төлбөр болгож авахыг бүх нийтээр зөвшөөрч байгаа солилцооны хэрэгслэлийг мөнгө гэдэг.

Дээр үед хүмүүс алт, мөнгөө хадгалуулдаг гол газар нь зориулалтын бөх савтай алтны дархчууд байв. Яваандаа дархан хадгалуулсан алт, мөнгөний оронд тасалбар өгдөг болсон ба тэр тасалбарыг авчирсан хэнд ч алт, мөнгийг нь өгөх тул хүмүүс арилжаа хийх болгондоо дархнаас очиж алт, мөнгө авахын оронд тасалбараа солилцох болжээ. Энэ нь цаасан мөнгөний анхны хэлбэр байв.

Нөгөө талаар хүмүүс наймаа хийх болгондоо алт шаардахгүй болсон тул дархан тэр хооронд алтыг нь ашиглах, хадгалуулсан алтаас илүү их тасалбар олгож зээлдүүлэх болсноор энэ нь банк үүсэх эхлэл болсон байна.

Орчин үед эдийн засаг дахь мөнгөнд улсаас баталгаажуулсан мөнгөн тэмдэгтүүд, банкны систем дэх хадгаламж хамаарагддаг. Мөнгөн тэмдэгтийг алт зэрэг үнэт металлээр чөлөөтэй солихоо больж, өөрөөр хэлбэл бодитой хязгаарлалтгүй болсон. Гэхдээ алтны хязгаарлалтгүй болсноор төрөөс шинэ мөнгө үйлдвэрлэх замаар орлогоос хэтэрсэн зардал гаргаж инфляци үүсгэх эрсдэл байгаагийн зэрэгцээ эдийн засаг дахь мөнгийг алт, мөнгөний олборлолтын хэмжээнд баригдуулахгүй, тухайн үеийн эдийн засгийн нөхцөл, ирээдүйн төлөвтэй уялдуулан зохицуулах бололцоотой болсон давуу талтай юм. Тиймээс үнийн өсөлтийг ард, иргэдийн амьжиргааг бууруулахгүй түвшинд байлгахаар эдийн засаг дахь мөнгөний хэмжээг удирдах зорилго бүхий институтыг байгуулах хэрэгцээ бий болжээ. Арилжааны олон банкуудаас гадна зээл олгож, нөөцийг хянаж байдаг Төв банк гэж улс болгонд байдаг. Төв банк нь нийт эдийн засаг дахь мөнгөний хэмжээ, зээлийн нөхцөл зэргийг хянан зохицуулж байдаг.

Өнөөдөр зах зээлийн өндөр хөгжилтэй орнуудад хэдийгээр уг зориулалтаараа солилцооны хэрэгсэл биш боловч амархан хөрвүүлж болох “гүйлгээний” чадвар өндөртэй санхүүгийн

хэрэгслүүд олноор үүссэнийг “бараг мөнгө” гэж нэрлэх болсон. Жишээ нь: төрөл бүрийн хадгаламж, хадгаламжийн сертификат, чек, хувьцаа, бонд зэргийг мөнгөний адил худалдан авалт хийхэд ашиглах тул бэлэн мөнгөтэй ижил үүрэг гүйцэтгэдэг. Ийм учраас эдийн засагт байгаа мөнгөний хэмжээг бэлэн мөнгөнөөс гадна өргөн утгаар нь тодорхойлж, тооцоолох шаардлага бий болжээ. Үүнд:

- Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө
- М1 буюу мөнгө-1 гэдэг үзүүлэлтэд гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, хугацаагүй хадгаламж, аялагчдын чекийг оруулдаг. Зах зээлийн хөгжсөн орнуудад дунджаар М1 мөнгөний 1/4 нь бэлэн мөнгө, 3/4 хувь нь банкны хадгаламж эзэлж байдаг.
- М2 буюу мөнгө-2 гэдэг үзүүлэлтэд М1 дээр хугацаатай хадгаламж нэмэгддэг.
- М3 буюу мөнгө-3 гэдэг үзүүлэлтэд М2 дээр тухайн орны иргэдэд байгаа гадаадын мөнгийг оруулж тооцдог.

Ер нь орчин үед санхүүгийн салбарт электрон техник өргөн нэвтэрч байгаагийн улмаас эдийн засгийн үүднээс мөнгө, мөнгө биш хөрөнгийг ялгаж тооцох явдал улам нарийн төвөгтэй болж байна. Хэрэглэгчид /өрх гэрүүд/ баялгаа янз бүрийн хэлбэрээр хадгалдаг. Тухайлбал, банкин дахь хадгаламж, өөрт байгаа бэлэн мөнгө, үнэт цаас, худалдан авсан хөрөнгө оруулалт, газар байшин гэх мэт бодит капитал зэргийг дурдаж болно. Эдгээрийг ерөнхийд нь:

- Мөнгө, банкны хугацаагүй хадгаламж зэрэг өөрөө хүүгийн орлого оруулдаггүй боловч шууд солилцооны хэрэгслийн үүрэг гүйцэтгэж чаддаг, өөрөөр хэлвэл зуун хувийн “гүйлгээний” чанартай зүйлүүд,
- Хувьцаа, бонд зэрэг хүүгийн орлого оруулахын зэрэгцээ солилцооны үндсэн хэрэгсэл биш боловч үнэт цаасны зах зээл дээр онцын бэрхшээлгүй зарж бэлэн мөнгө болгож болох зүйлүүд,
- Машин, техник, байшин барилга зэрэг ашиг орлоготой боловч солилцооны хэрэгслийн хувьд үндсэндээ гүйлгээний чадваргүй бодит капитал гэж ялгаж болно.

Энд “гүйлгээ” буюу “ликвидити” гэдэг ойлголт нь санхүүгийн чөлөөтэй хөрвөх чадварыг хэлж байгаа болно.



Гэхдээ эдийн засаг дахь мөнгөний талын тэнцвэрийн тухай ойлголтыг хялбарчлах үүднээс зах зээлийн эдийн засгийн онолд төгс “гүйлгээний” чадвартай солилцооны хэрэгсэл буюу **мөнгө**, гүйлгээний чадвар нь төгс биш боловч хүү, орлого оруулж байдаг бусад хэрэгсэл буюу нийтэд нь **“бонд”** гэсэн санхүүгийн үндсэн 2 төрлийн хэрэгсэл байна гэж үздэг.

Бонд нь дараахь гол шинж чанартай байдаг.

- Бондын зах зээл дээр зарагдах үнэ нь түүнээс ирээдүйд орох орлогын урсгалын өнөөдрийн үнээр илэрхийлэгдэнэ.
- Зах зээлийн хүү ба бондын үнэ урвуу харьцаатай байдаг.

Зах зээлийн эдийн засагт хэрэглэгч хөрөнгө баялгаа мөнгө болгох уу, бонд болгох уу гэсэн асуудалтай байнга тулгардаг.

а. Мөнгө болговол хэзээ ч, юунд ч хэрэглэж болох төгс “гүйлгээ”-тэй солилцооны хэрэгсэлтэй болох боловч бондноос олох байсан ашиг, орлогыг алдана.

б. Бонд болговол хөрөнгө сул зогсохгүй, хүү авч байх боловч дуртай цагтаа хүссэн зүйлдээ зарцуулах төгс гүйлгээтэй хэрэгслээ алдана.


## **Б. БАНК ЯАЖ МӨНГИЙГ ҮРЖҮҮЛДЭГ ВЭ?**

Банкны системд оруулсан 1 төгрөг нь банкны системээс гарч бодит эдийн засгийн гүйлгээнд зарцуулагдан буцаж банкны системд орон банкны хадгадамжийн хэмжээг нэмэгдүүлэх буюу энэ процесс хэдэн удаа давтагдахын хирээр мөнгөний хэмжээ хэд дахин үржигдэх нь тодорхойлогдоно. Банк шинээр орж ирсэн хадгаламийн хэмжээгээр шинээр зээл олгох замаар мөнгө, зээлийн үзүүлэлтүүд үржигдэн нэмэгддэг.

Онолын хувьд эдийн засагт мөнгө дараах 2 сувгаар нийлүүлэгддэг гэж үздэг. Нэгдүгээрт, Төв банк мөнгөний сул бодлогыг хэрэгжүүлэхдээ нээлттэй цонхны үйл ажиллагаа, заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулах, бусад хэрэгслүүдээ ашиглан банкуудад санхүүжилт хийх, гадаад валютын арилжаагаар төгрөг нийлүүлэх тохиолодолд банкны системд

мөнгө шинээр нийлүүлэгдэнэ. Хоёрдугаарт, Засгийн газраас төсвийн зардлыг Төв банкин дахь данснаасаа санхүүжүүлэх замаар нөөц мөнгийг нэмэгдүүлдэг. Нөөц мөнгөний өсөлт нь мөнгө үржих үйл явцаар буюу зээл, хадгаламжийн үйл ажиллагаагаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг.

### Мөнгө үржих үйл явц



### ЗБН-Заавал байлгах нөөц

Мөнгө үржих үйл явцыг дээрх схемд үзүүлсэнийг энгийн жишээгээр тайлбарлая.

(Заавал байлгах нөөцийн хувийг 10 хувь гэж үзье.) Эхний банк буюу “Банк-1” Төв банкнаас зээл авч, хугацааны т агшинд “Компани-1”-д 100 төгрөгийн зээл олгосон гэж үзэв. “Компани-1” нь банкнаас авсан зээлээ эдийн засгийн эргэлтэнд оруулж, “Компани-2”-т бараа, үйлчилгээ худалдан авсны төлбөр хийв. “Компани-2”-ийн орлого болох 100 төгрөгийн 20 төгрөг нь эдийн засагт бэлэн мөнгө хэлбэрээр байршсан гэж үзье. Тэгвэл үлдэх 80 төгрөг нь “Компани-2”-ийн харилцагч банк болох “Банк-2”-т харилцах, хадгаламж хэлбэрээр байршина. “Банк-2” нь шинээр нэмэгдсэн 80 төгрөгийн эх үүсвэрийн 10 хувь буюу 8 төгрөгийг заавал байлгах нөөцөд байршуулж, үлдсэн 72 төгрөгийг зээл хэлбэрээр гаргах боломжтой юм.

Иймээс “Банк-2” илүүдэл нөөц болох 72 төгрөгөө “Компани-3”-т зээл болгон олгож, “Компани-3” нь авсан зээлээ “Компани-4”-өөс бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулжээ. Үүний 12 төгрөг нь эдийн засагт бэлэн мөнгө хэлбэрээр байршиж, үлдэх 60 төгрөг нь “Банк-3”-т “Компани-4”-ийн харилцах, хадгаламж хэлбэрээр байршина. “Банк-3” нь 60 төгрөгийн нэмэгдсэн эх

үүсвэрийн 10 хувийг ЗБН-д байршуулж, үлдэх 54 төгрөгийг зээлд гаргах боломжтой юм. Энэ процесс цаашид системийн илүүдэл нөөц шавхагдах хүртэл үргэлжилнэ. Доорх зурагт мөнгө үржих процессийг тоон утгаар үзүүллээ.

Хүснэгт 1. Мөнгө үржих үйл явц, тоон үзүүлэлтээр

Банк	Хадгаламжийн хэмжээ	Зээл олгох боломжтой хэмжээ	ЗБН
1	100	90	10
2	90	81	9
3	81	72.9	8.1
4	72.9		
	Мөнгө үржих процессоор үүссэн нийт хадгаламжийн хэмжээ	Мөнгө үржих процессоор үүссэн нийт зээлийн хэмжээ	ЗБН-ийн өсөлт
	271	243.9	27.1

### ***В. ТӨВ БАНК ЯМАР ЧИГ ҮҮРЭГТЭЙ ВЭ?***

1. Үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах
2. Төлбөр тооцооны гүйлгээний тасралтгүй, чөлөөт эргэлтийг хангах
3. Арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банкны системийн тогтвортой байдлыг бэхжүүлэх

### ***Г. ТӨВ БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД БОДЛОГЫН ЯМАР ХЭРЭГСЛҮҮД АШИГЛАДАГ ВЭ?***

- **Мөнгөний нээлттэй зах зээл дээр явуулах үйл ажиллагаа**

Төв банк банк хоорондын захын нөөцийн илүүдлийг татах эсвэл дутагдлыг хангах зорилгоор банкуудад Төв банкны үнэт цаас худалдах, худадан авах үйл ажиллагааг нээлттэй захын үйл ажиллагаа гэнэ.

- **Санхүүжилтийн хэрэгслүүд:**

Богино хугацааны болон түр зуурын санхүүжилт



шаардлагатай нөхцөлд банк өөрийн эзэмшиж буй Засгийн газрын болон Төв банкны үнэт цаасыг барьцаалан санхүүжилт авахыг хэлнэ.

- **Бодлогын хүүний өөрчлөлтийн бодлого:**

Мөнгөний захын эрэлт, нийлүүлэлтээс гадна макро эдийн засгийн тухайн болон ирээдүйн нөхцөл өөрчлөгдөх төлөв дээр үндэслэн мөнгөний бодлогын хүү болох 7 хоногтой Төв банкны үнэт цаасны хүүгийн хэмжээг өөрчилдөг.

- **Заавал байлгах нөөцийн хувийг өөрчлөх:**

Төв банкин дахь дансанд банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хувийг заавал байлгах нөөц хэлбэрээр байршуулахыг заавал байлгах нөөц гэнэ. Заавал байлгах нөөцийн хувийг өөрчлөх нь эдийн засаг дахь зээлийн хэмжээг түргэн хугацаанд хумих эсвэл өргөжүүлэхэд нөлөөлдөг.

#### ***Д. БАНКНЫ СИСТЕМД ЯАГААД ТОГТВОРГУЙ БАЙДАЛ ҮҮСДЭГ ВЭ?***

- Үндэсний валютын ханшны тогтворгүй байдлын улмаас
- Мөнгөний талаарх оновчгүй бодлогын уршгаас
- Улсын төсөв- санхүүгийн тэнцвэртэй бус бодлогын улмаас
- Хадгаламжийн даатгалын тогтолцоо байхгүйгээс

#### ***Е. БАНКНЫ СИСТЕМИЙГ ТОГТВОРТОЙ БАЙЛГАХЫН ТУЛД ЯАХ ВЭ?***

- Банк-санхүүгийн тогтолцооны эрх зүйн орчинг боловсронгуй болгох
- Банкин дахь нөөцийн доод хэмжээний түвшин болон Төв банкны бодлогын хүүгийн түвшний тохиргоог хийх
- Банкны мөнгө санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэ хэлбэрүүдийг хөгжүүлэх, мөнгөний зах зээлийн багтаамжийг зохицуулах

## ХОЁР. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТУХАЙ ТОЙМ ОЙЛГОЛТ

Мөнгөний бодлогын мөн чанар нь эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт, зээлийн нөхцлийг өөрчлөх замаар макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд нөлөөлөхөд оршдог.

Эдийн засаг хүчин чадлаа **бүрэн ашиглаагүй** байгаа нөхцөлд мөнгөний хэмжээг /нийлүүлэлтийг/ өсгөвөл үнийн өсөлтийг бий болгохгүйгээр нийт эрэлт болон үндэсний орлогын хэмжээг өсгөх боломжтой. Харин мөнгөний нийлүүлэлтийг багасгавал үүний сөрөг үзэгдэл явагдаж, эдийн засгийн өсөлтийг бууруулдаг.

Хэрэв эдийн засаг **бүрэн ажиллаж** байгаа нөхцөлд мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэвэл үндэсний үйлдвэрлэл өсөх хэдий ч нэрлэсэн өсөлтийн дийлэнх илүүдэл эрэлтийг бий болгож үнийн өсөлтийг дагуулдаг. Өөрөөр хэлвэл инфляцийг нэмэгдүүлнэ. Иймд эдийн засаг хүчин чадлаа **бүрэн ашигласан** үед инфляцийн дарамт нэмэгдэж, эдийн засаг “хэт” халдаг тул мөнгөний нийлүүлэлтийг багасгах эсвэл бодлогын хүүг өсгөх замаар нийт эрэлтийг бууруулан инфляцийг хазаарлах бодлогыг хэрэгжүүлдэг. Мөнгөний нийлүүлэлтийг багасгах болон хүүг өсгөх бодлогын арга хэмжээнүүд нь эцэстээ хөрөнгө оруулалтын бууралтаар дамжин үйлдвэрлэлт, нийт эрэлтийг бууруулах замаар инфляцийг бууруулах нөлөөг үзүүлдэг. Ийнхүү мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхдээ мөнгөний биет хэмжээ болон хүүг өөрчлөх замаар нийт эрэлтийг өөрчилж, үндэсний орлогын тэнцвэрт хэмжээнд нөлөөлөхийг мөнгөний бодлогын нөлөөллийн суваг гэж нэрлэдэг.

**Тайлбар:**

*“Мөнгөний бодлогын тайлбарыг бага зэрэг тодруулж сонирхоё. **Тэнцвэртэй** байгаа эдийн засагт мөнгөний нийлүүлэлтийг ихэсгэвэл илүүдэл нийлүүлэлт, багасгавал илүүдэл эрэлт үүснэ. Сонгодог эдийн засагт бол мөнгөний нийлүүлэлт ихэсвэл түүнийг зарцуулах нь өсөх тул эдийн засаг өснө, мөнгөний нийлүүлэлт багасвал зарцуулалт хорогдож, эдийн засгийн идэвхжил буурна гэсэн хэт хялбарчилсан үзэл ноёрхож байв. Харин шинэ Кейнсийн онолоор бол мөнгөний нийлүүлэлт эрэлтээс давахад хүмүүс мөнгөөрөө бонд авч эхэлнэ. /Амьдрал дээр бонд гэдэгт ашиг орлоготой эд баялгийн бүхий л хэлбэрийг багтаан ойлгож болно/. Ингээд бондын үнэ өсөж, түвшин буурна. Хүү буурахад зээл авахад амар хямд болж удаан хугацааны хөрөнгө оруулсны өртөг зардал багасах учир удаан эдэлгээтэй бараа, борлуулаагүй барааны нөөц, орон сууц, барилга, хөрөнгө оруулалт бүгд өсөж, эдийн засаг нийтдээ идэвхжинэ гэж тайлбарладаг”*

Төв банкнаас мөнгөний зах зээлд оролцож нийлүүлэлтэд нөлөөлөх энэ аргыг “нээлттэй зах зээлийн ажиллагаа” гэж нэрлэдэг.

Мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх **өөр нэг зам** бол арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хувийг **өөрчлөх** арга юм. Банкуудын заавал байлгах нөөцийн хувийг багасгах нь тэдгээрийн Төв банкинд байршуулах нөөцийн хэмжээ багасч, зээл гаргах эх үүсвэр нэмэгддэг. Заавал байлгах нөөцийн хувь нэмэгдсэнээр банк заавал байлгах нөөц хэлбэрээр байршуулах нөөцийн хэмжээ нэмэгдэж, зээл гаргах эх үүсвэр нь буурч, ингэснээр нийт зээл буурч, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт хорогдоно.

Бид мөнгөний эрэлт, нийлүүлэлт нь /хүмүүс бонд буюу мөнгө авах нь/ хүүгийн түвшингээс шалтгаалдаг талаар өмнө дурдсан. Мөнгөний эрэлт ба хүүгийн түвшин тогтвортой хамааралтай нөхцөлд Төв банкнаас мөнгөний хэмжээнд нөлөөлж болох **нэг зам нь хүүг** өөрчлөх арга болдог. Жишээ нь: Мөнгөний эрэлт, хүүгийн харьцаа тэнцвэртэй байх үед мөнгөний эрэлтийг нэмэгдүүлэх гэвэл хүүг буулгах хэрэгтэй болно гэсэн үг юм. Гэвч энэ тохиолдолд хүүгийн өөрчлөлт хөрөнгө оруулалт зэрэг эдийн засгийн бусад чухал хүчин зүйлүүдэд хэрхэн нөлөөлөхийг тооцох хэрэгтэй болдог.

Төв банкны мөнгөний хэмжээг хянах чадварт Төв банкны мэдлээс гадуур байдаг зарим хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд: Засгийн газрын зарцуулалт, банкинд мөнгөө хадгалуулах, бэлнээр барих, бонд худалдаж авах талаарх банкны харилцагчийн шийдвэр болон банкны өөрийн үйл хөдлөл зэргээс шалтгаалан Төв банкны хамааралгүйгээр мөнгөний нийлүүлэлт өөрчлөгдөх боломжтой. Үүнийг мөнгөний бодлогын автомат нөлөөлөл гэж нэрлэдэг бөгөөд түүнийг мөнгөний бодлогын хэрэгслүүдээр засах шаардлага байнга тулгардаг байна.

\* \* \*


## **БИД БАНК, МӨНГӨНИЙ ТАЛААРХ ТОВЧ ОЙЛГОЛТОНДОО ТУЛГУУРЛААД 2015 ОНЫ ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛТЭЙ ТАНИЛЦАЦГААЯ**





# I ХЭСЭГ

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ



М2 мөнгө	2880	4880	48	5	5773	764
М1 мөнгө	851	1138	17	2	1553	76
Бараг мөнгө	2229	3522	31	4	4220	4
Гадаад цэвэр зээл	235	2739	619	2950	304	
Гадаад цэвэр зээл	184	3023	886	3260	334	
Төв банкны цэвэр зээл	16	262	656	2951	3084	
Арилжааны банкны цэвэр зээл	119	339	320	309	259	
Бусад цэвэр зээл	-160	329	-267	-310	-303	
Дотоод цэвэр зээл	1347	1336	2336	2823	3024	
Дотоод цэвэр зээл	1938	2400	2735	3380	3711	
ЗГ-ын цэвэр зээл	-717	-835	-996	-1173	-1350	
Хөгжлийн банкны цэвэр зээл*						
Хасах авах авч үзэх	2655	3265	3731	4553	5060	
Бусад цэвэр зүйл	-591	-489	-399	-557	-687	
Төв банкны цэвэр зээл						
Төв мөнгө	733	945	1019	1260	1399	
Гадаад цэвэр актив	1539	2529	2470	2850	2983	
Дотоод цэвэр актив	-806	-1584	-1451	-1590	-1584	
ЗГ-ын цэвэр зээл	-265	-492	-627	-827	-958	
Хөгжлийн банкны цэвэр зээл*						
Банкны олгосон зээл	198	131	128	215	118	
Хасах нь: ТБУЦ	393	1101	1173	1147	881	
Бусад цэвэр зүйл	-346	-122	221	169	137	

Энэ хэсгээс мөнгөний бодлогод хэрэглэгддэг зарим үндсэн үзүүлэлтүүдийн тодорхойлолт, тооцооны зарим аргачилалын талаар товч ойлголт авах бөгөөд 2015 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлтэй “зорилт ---арга хэмжээ --- хүлээгдэж буй гүйцэтгэл” гэсэн дарааллаар танилцаж, улмаар Төрөөс мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг боловсруулах, хэлэлцэх, батлах, гүйцэтгэлийг хангахад “Та” иргэнийхээ хувьд оролцох, санал бодлоо илэрхийлэх боломжийг олно.



## 1.1. 2015 ОНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ГОЛ АГУУЛГА



### 1.1.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ 2015 ОНД






## Тодруулга 1

### ✓ **Боломжгүй гурвал:**

Дэлхийн төв банкууд 1/аливаа гадаад гүйлгээнд хязгаарлалтгүй буюу валютын орох, гарах урсгал нээлттэй, 2/үндэсний валютын нэрлэсэн ханшаа тогтвортой, 3/мөнгөний бодлогоо бусад улс орноос хараат бусаар хэрэгжүүлэхийг зорьж байсан тохиолдол олон байдаг. Мөнгөний хараат бус байдал гэдэг нь өөр улс орноос үл хамааран дотоодын инфляцийг удирдах чадвар юм.

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр дээрх зорилтууд өөр хоорондоо зөрчилдөх нь олон орны жишээн дээр харагдаж байсан бөгөөд 1960 онд Роберт Мюнденел, Маркус Флеминг нар эдгээр 3 зорилт нэгэн зэрэг хангагдах ямар ч боломжгүй, зөвхөн аль нэг хос зорилт л хангагдах боломжтой гэсэн үндэслэл гаргаснаар “Боломжгүй гурвал” гэсэн ойлголт бий болжээ.

Хөрөнгийн чөлөөт урсгал



Тухайлбал, Төв банк А хувилбарт хамаарах 2 зорилтыг зэрэг хэрэгжүүлэх гэвэл хараат бус мөнгөний бодлогоос татгалзах шаардлагатай болно гэсэн үг юм.

### **А хувилбар: Тогтмол ханш болон хөрөнгийн чөлөөтэй урсгал**

А–хувилбарыг сонгох тохиолдолд Төв банк бие даасан хараат бус мөнгөний бодлогыг хэрэгжүүлж чадахгүй. Жишээ нь хөрөнгийн урсгал гадагшилж эхэлсэн /хөрөнгийн урсгал чөлөөтэй тул/ гэж саная. Нэгэнт валют гадагшлах тул дотоодын валютын ханшид сулрах дарамт ирнэ. Ханшийг сулруулахгүйн тулд Төв банк хүүг өсгөх шаардлагатай болно. Гэтэл энэ үед бизнесийн идэвхжлийг дэмжихийн тулд хүүг бууруулах шаардлага байсан бол энэ нь эдийн засгийн өсөлтөд шууд сөргөөр нөлөөлөх болно. Эндээс Төв банк нь мөнгөний бодлогоо хараат бусаар хэрэгжүүлэх ямар ч сонголтгүй, зөвхөн дотоодын валютын ханшийг хамгаалах чиглэлд хүүгээ хөдөлгөхөөс өөр сонголтгүй болох нь харагдаж байна. Нөгөө талд ханшийн сулралтыг хүүгээр бус валютын интервенц хийх замаар зогсоох гэж оролдож болох ч, энэ нь валютын нөөцөө алдах, улмаар ханшаа тогтмол барих гэж оролдоод нийт эдийн засгаа хямралд өртүүлэх явуур муутай үйлдэл болох юм. Ялангуяа гадаад валютын нөөц, валютын

## Тодруулга 1-ын үргэлжлэл

орлого багатай, урсгал тэнцэл нь алдагдалтай, үндэсний хуримтлал бүрдээгүй, эдийн засгийн дархлаа султай орны хувьд А хувилбар хэзээ ч тохирохгүй.

### **Б хувилбар: Хараат бус мөнгөний бодлого ба Хөрөнгийн чөлөөт урсгал**

Төв банк Б хувилбарыг сонговол чөлөөт ханшийн дэглэмтэй байна (Тухайлбал, АНУ-ын ХНБ). Эдийн засгийн нөхцөл байдал муудсанаас шалтгаалан Төв банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, хүүний түвшинг бууруулсан гэе. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагчид өгөөж багатай дотоодын валютыг бус харин илүү өгөөжтэй гадаад валютын илүүд үзэх тул дотоодын валютын ханш сулрах дарамттай тулгарна. Засгийн газрын хувьд эдийн засгийн өсөлт юу юунаас чухал тул хүүг бага түвшинд хадгалж ханшаа сулруулахаас өөр аргагүйд хүрнэ. Ханшийн сулралтыг зогсоохын тулд валютын нөөцөөс зарж болох ч, энэ хувилбарын хувьд интервенц нь ханшийг хамгаалахад бус, зөвхөн хэлбэлзлийг зөөлрүүлэхээр хязгаарлагдана. Иймд дотоодын валютын ханш нь эдийн засгийн суурь нөхцөлөөс хамаарч уян хатан тогтох ба ингэснээр гадаад орчны сөрөг өөрчлөлтийн дотоодын эдийн засаг дахь таагүй нөлөөллийг ханш өөртөө шингээгч нь болох юм. Хөрөнгө оруулалт ихээр шаардлагатай, нээлттэй бөгөөд чөлөөт эдийн засагтай, гадаад зах зээлээс хамаарал өндөртэй, хараат бус мөнгөний бодлого бүхий орны хувьд энэ хувилбар хамгийн тохиромжтой.

### **В хувилбар: Тогтмол ханш ба Хараат бус мөнгөний бодлого**

Хэрвээ Төв банк мөнгөний бодлогоо бусад улсын Төв банкнаас хараат бусаар хэрэгжүүлэхэд ханшаа тогтмол түвшинд барих сонирхолтой бол хөрөнгийн урсгалд зайлшгүй хязгаарлалт тогтоох шаардлагатай болно /Тухайлбал, Хятадын Төв банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, хүүгийн төвшинг бууруулсан гэе. Нөгөө талаас дэлхийн санхүүгийн хямрал дотоодын валютын ханш сулруулах дарамтыг бий болгож болно. Энэ нөхцөлд ханшийг тогтмол барих цорын ганц арга зам нь хөрөнгийн гадагшлах урсгалыг хүчээр зогсоож хяналт тавихад оршино. Урсгал тэнцэл, улмаар төлбөрийн тэнцэл нь байнгын ашигтай байдаг, дотоодын үйлдвэрлэл, экспортын чадамж үлэмж хөгжсөн, үндэсний хуримтлал ихтэй, гадаад валютын хэрэгцээ шаардлага багатай, дархлаа сайтай эдийн засагт энэ нь байж болох хувилбар боловч манайх шиг эдийн засагт огт тохирохгүй хувилбар.

### 1.1.2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ( ЗАХ ЗЭЭЛИЙН) ТОГТВОРТОЙ БАЙДАЛД МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ 2015 ОНД



## 1.2. 2014 ОНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛТУУД

З  
О  
Р  
И  
Л  
Т

2015

- ✓ Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2016–2017 онд энэ түвшинд тогтворжуулах бодлогын оновчтой хувилбарыг сонгон иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, улмаар дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.
- ✓ Банкуудын төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар системийн болзошгүй эрсдэлээс хамгаалах чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын дархлааг сайжруулна.
- ✓ Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлнэ.
- ✓ Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох эрх зүйн орчныг сайжруулах боломжийг судалж, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагатай хамтран үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.
- ✓ Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр ажиллана.
- ✓ Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.
- ✓ Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон, мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлэн, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална. Энэ хүрээнд инфляцийн төлөв байдлын илтгэлийг улирал бүр, санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдон Байнгын хороонд хүргүүлнэ.
- ✓ Санхүүгийн зах зээлд экспортын болон давхар даатгалын оновчтой тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлнэ.
- ✓ Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг мөнгөн хадгаламжийн даатгалд хамруулах бэлтгэл ажлыг хангана.
- ✓ Тогтвортой санхүүжилтийн санаачилгыг дэмжиж ажиллана.

### **1.2.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ТАВИГДАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

З  
О  
Р  
И  
Л  
Т

2015

- ✓ Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2016–2017 онд энэ түвшинд тогтворжуулах бодлогын оновчтой хувилбарыг сонгон иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, улмаар дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.


## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- Монголбанк эрсдэлд суурилсан макро зохистой бодлогын арга хэрэгслийг мөнгөний бодлоготой нягт уялдуулснаар зээлийн идэвхлийг сэргээх, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, уг салбарын дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана. Ялангуяа валютын зээлийн эрсдэлийг бууруулах, зээлийн төвлөрлийг сааруулах, зээлийн багцын чанарыг сайжруулах, банкуудын валютын ханшийн эрсдэлийг удирдах чадавхыг бэхжүүлэхэд макро болон микро зохистой бодлогын арга хэмжээг чиглүүлнэ.
- Эдийн засгийн мөчлөгийг сөрөх мөнгөний болон макро зохистой бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нь ирээдүйд учирч болзошгүй эдийн засгийн тогтворгүй байдлын эрсдэлээс сэргийлэхэд туйлын чухал юм. Монголбанк санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг илүү боловсронгуй болгож, тэдгээрийн зах зээл дэх хэрэглээг нь нэмэгдүүлэх замаар зах зээлд оролцогчдын валютын ханшийн болон хүүгийн эрсдэлээ удирдах боломжийг сайжруулна. Мөн банкны салбарын төлбөрийн чадварыг хамгаалах, системийн хяналт шалгалт, зохистой харьцааны дүрэм, журмыг сайжруулах, банкны салбарт учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх замаар ард иргэдийн санхүүгийн салбарт итгэх итгэлийг хадгалахад онцгой анхаарч ажиллана.
- Орон сууцны ипотекийн санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бүрдүүлж, дундаж давхаргын хуримтлалыг тууштай нэмэгдүүлэх замаар дотоодын зээл, хуримтлал, хөрөнгө оруулалтыг урамшуулж, эдийн засгийн дархлааг сайжруулах бодлогоо Монголбанкнаас Засгийн газар, банкууд, МИК-тай хамтран үргэлжлүүлэх болно.
- Монголбанк макро эдийн засгийн ирээдүйн төлөвт суурилан, ирээдүйд чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлж хэвших, инфляцийн зорилтыг хангах замаар инфляцийн хүлээлтийг төлөвшүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.
- Монголбанк орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөрөөс бусад хөтөлбөрийн зээлийг бууруулах замаар тэдгээр хөтөлбөрөөс үе шаттай гарах зарчим баримтална.



### 1.2.1а. ИНФЛЯЦИЙН ТҮВШИН 2015 ОНД



## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах”, “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах”, “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах”, “Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах”, “Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтворжуулах” гэсэн 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд Монголбанкны оролцоог багасгаж, өмчлөлийг нь Засгийн газарт шилжүүлэх шат дараатай арга хэмжээг үе шаттайгаар сонгон хэрэгжүүлнэ.
- Инфляцийн хүлээлтийг төлөвшүүлэхэд онцгой анхаарч “Төсөөлөл бодлогын шинжилгээний систем (FPAS)”-ийн загварыг ашиглан төсөөлөл хийх тогтолцоог нэвтрүүлснээр бодлогын хариу үйлдэл, эдийн засаг дахь сөрөг нөлөөллийн шалтгаан, эдийн засаг хэрхэн ажилладаг талаарх төрөл бүрийн таамаглалуудаас гарсан эрсдэлүүдийг авч үзэх боломжтой болж, мөнгөний бодлогын шийдвэр гаргалт улам бүр сайжирна.
- Нийлүүлэлтийн гаралтай инфляцийг аймаг, нийслэлийн түвшинд нам, тогтвортой байлгах арга хэмжээ авна.

### **Хэрэглээний үнийн индекс /инфляци/ 2014 оны эхний 11 сарын урьдчилсан гүйцэтгэлээр**

- Хэрэглээний үнийн улсын индекс 2014 оны 11 дүгээр сарын эцэст өмнөх сараас 0.7 хувь, оны эхнээс 10,1 хувь, өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар тус тус өслөө.
- Монголбанкнаас мөнгөний бодлогын уламжлалт бус арга хэрэгслээр инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгаж, Засгийн газартай хамтран нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөллийг бууруулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд тэдгээрийг зах зээлийн механизмд суурилсан байнгын тогтолцоо руу шилжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.
- Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 02 дугаар сарын 07–11–ний өдрүүдэд хуралдаж, Бодлогын хүүг 10.5%–д хэвээр үлдээх, олон улсын зах зээл дээрээс 3 болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээл хэлбэрээр банкны татсан гадаад валютын эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлөх шийдвэрийг гаргасан. Бодлогын энэхүү арга хэмжээ нь нэг талаас эдийн засгийн бодит секторын идэвхжлийг дэмжих, нөлөө талаас гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив огцом буурсан, төлбөрийн тэнцлийн дарамт өндөр байгаа орчинд гадаад валютын урт хугацаатай эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилготой байв. Суурь инфляцийн түвшин сүүлийн 11 сарын турш эрчимжиж, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад цэвэр актив буурах хандлага үргэлжилж, төсөвтэй адилтгах хөрөнгө оруулалтын зарцуулалтууд буурахгүй байсан тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2014 оны 7 дугаар сарын 30–ны өдрийн ээлжит хуралдаанаар мөнгөний бодлогын хүүг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн, 12.0 хувь болгох шийдвэр гаргав. Энэхүү арга хэмжээ нь төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилготой.

## Тодруулга 2



### **Инфляци /үнийн ерөнхий түвшин/ :**

Энэ нь эдийн засагт үнийн ерөнхий түвшин нэмэгдэх байдлаар илэрдэг мөнгөний үнэгүйдэх /мөнгөний үнэ цэнэ, ханш буурах/ үйл явц бөгөөд үнийн индексийн тусламжтай хэмжиж байгаа өргөн хэрэглээний бүлэг барааны буюу хэрэглээний сагс болгон тооцсон барааны үнийн дундаж түвшингээр тодорхойлогддог.

### ✓ **Өндөр инфляцийн үр дагавар:**

- Хүн амын амьдралын түвшинг бууруулна.
- Хувийн хадгаламжийн бодит үнэ цэнэ болон бодит орлого буурна.
- Хүн амын бодит орлогын хэмжээ цалинг нэмсэн ч мөн буурсаар л байх болно.
- Татвар нэмэгдүүлэх хэрэглүүр болно.
- Хөдөлмөрт урамших, үйлдвэрлэлийг өргөжүүлэх сонирхол буурснаас үйлдвэрлэл буурна.
- Жолоодлогогүй инфляци нь эдийн засгийг бүхэлд нь удирдлагагүй болгоно.

### ✓ **Өндөр инфляцийн эсрэг авах арга хэмжээ:**

- Инфляцийн хүлээлтийг тогтворжуулах
- Мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах /Мөнгөний хатуу бодлого/
- Төсвийн хумих бодлого хэрэгжүүлэх, алдагдлыг бууруулах
- Татварын шинэчлэл хийх
- Валютийн ханшийг тогтворжуулах
- Эдийн засгийн таваарлаг байдлыг дээшлүүлэх
- Мөнгөний шинэчлэл хийх / онцгой тохиолдолд /

### ✓ **Нийлүүлэлтийн гаралтай инфляци:**

- Үйлдвэрлэл, нийлүүлэлтийн доголдлын улмаас болон хүлээгдэж буй өндөр зардлыг нөхөхтэй холбогдсон үнийн хөөрөлтөөр өдөөгдсөн инфляцийг зардлын буюу нийлүүлэлтийн гаралтай инфляци гэдэг. Мах, гурил, шатахуун, цахилгаан, дулаан, импортын бараа түүний тээврийн зардал гэх мэт нь гол хүчин зүйлс нь юм. Манай орны хувьд мах болон шатахууны үнийн өөрчлөлт нь инфляци, түүний хэлбэлзлийг өдөөгч нийлүүлэлтийн үндсэн хүчин зүйл болж байна.

## Тодруулга 2-ын үргэлжлэл

Тухайлбал, сүүлчийн 3 жилийн дунджаар жилийн инфляцийн 40 гаруй хувийг суурь инфляци, 20 гаруй хувийг төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний инфляци, үлдсэн 40 орчим хувийг хүнсний бүтээгдэхүүний инфляци, үүнээс 24 хувийг нийлүүлэлт доголдсоны улмаас бий болсон махны үнийн өсөлт тус тус эзэлж байна. Нийлүүлэлтийн шалтгаантай инфляцийг мөнгөний бодлогоор бууруулах гэж оролдох нь эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй тул Засгийн газрын зохион байгуулалтын бодлого, арга хэмжээ чухал ач холбогдолтой байдаг.

### ✓ Эрэлтийн гаралтай инфляци:

- Илүүдэл эрэлтийн улмаас үүдсэн үнийн хөөрөлтөөр өдөөгдсөн инфляцийг эрэлтийн гаралтай инфляци гэдэг. Эрэлтийн гаралтай инфляцийг гол өдөөгч хүчин зүйлс нь төсвийн зардлын тэлэлт, хөрөнгийн урсгалын өсөлт, валютын ханшны хэт өндөр хэлбэлзэл гэх мэт болно. Тухайлбал, төсвийн бодлого богино хугацаанд хэт тэлэх нь эдийн засгийн халалтыг бий болгож, эрэлтийн гаралтай инфляцийг өдөөдөг. Энэ үед мөнгөний бодлогыг чангаруулан эдийн засгийн идэвхжилийг сулруулах замаар инфляцийн дарамтыг бууруулдаг.

Монголбанк үндсэн зорилтынхоо хүрээнд төгрөгийн тогтвортой байдлыг хангахын тулд дотоодын үнийн өсөлтийг тодорхой түвшинд тогтвортой барих зорилго тавьж ажилладаг. Гэхдээ Монголбанкнаас тухайн зорилтын хүрээнд авч хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын хэрэгслүүдийн үйлчлэх хүрээ хязгаарлагдмал буюу зөвхөн эрэлтийн шинж чанартай инфляцийн өсөлтийг бууруулахад чиглэгддэг. Иймээс нийлүүлэлтийн гаралтай хүчин зүйлсийн нөлөөг багасгах ажил ерөнхийдөө орхигдож ирсний улмаас сүүлийн жилүүдийн инфляцийн өсөлтийг нийлүүлэлтийн шинж чанартай буюу мах, гурил, шатахуун, цахилгаан дулааны үнийн өсөлт болон импортлож буй барааны үнэ дэх тээврийн зардлын хувь хэмжээ өсч байгаа зэрэг нь голлон тодорхойлох болсон. Ийм нөхцөлд Монголбанкны зүгээс эрэлтийн шинжтэй инфляцийг бага байлгах, Засгийн газрын зүгээс нийлүүлэлтийн шинж чанартай аливаа инфляцийн дарамтыг бий болгохгүй байх чиглэлд хамтран ажиллах шаардлагатай байдаг.


## Тодруулга 2-ын үргэлжлэл

- ✓ Үнийн тогтвортой байдлыг хангах нь Төв банкны зүгээс өндөр, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоход оруулж буй үндсэн хувь нэмэр юм. Манай улсын хувьд 8 орчим хувьд тогтвортой байх инфляци нь бодит эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөгүй, нийгмийн амьжиргааг хамгаалах боломж олгосон, эдийн засгийн бүтцийн өөрчлөлт эрчимтэй байх нөхцөл бүрдүүлсэн, нөөцийн хуваарилалт үр ашигтай байхад зохистой түвшин гэж Монголбанк үзэж байна. Энэ зорилго хэрэгжихэд макро эдийн засгийн бодлого цогцоороо эдийн засгийн тогтвортой өсөлтийг зорьсон байх нь нэн чухал юм. Түүнчлэн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн болон түлш шатахууны нийлүүлэлтийн тогтвортой байдлыг найдвартай болгох арга хэмжээг Засгийн газар авсан байх шаардлагатай.
- ✓ 8 хувийн тогтвортой инфляци нь санхүүгийн зуучлал гүнгийрч, зээлийн хүү одоогийн түвшний 2/3-т хүрч буурах боломжийг олгож, эдийн засгийн тогтвортой, өндөр өсөлт хадгалагдах боломжийг олгоно. Эдийн засгийн 10 хувийн бодит өсөлт нь ерөнхий цалингийн түвшинг хамгийн багадаа энэ хувиар өсөх боломжийг бүрдүүлэх тул бодит цалингийн орлого жил бүр 2-оос дээш хувиар нэмэгдэх нөхцөл бүрдэх юм. Үүний үр дүнд зээлийн хүү буурснаар иргэдийн зээлийн эргэн төлөлт дэх хүүгийн төлбөр 2-3 дахин багасч, худалдан авах чадвар нь мөн 2-3 дахин нэмэгдэх боломжтой.

## Монгол банкнаас инфляцийн тооцооны төсөөлөл хийдэг ерөнхий бүдүүвч



### Эрэлт, нийлүүлэлтийн инфляцийг бууруулах хариу бодлого гаргадаг бүдүүвч зураглал





### 1.2.16. ТӨГРӨГИЙН ХАНШ, ТҮҮНИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

З  
О  
Р  
И  
Л  
Т

2015

- ✓ Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, улмаар дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.



## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- Цаашид гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортын голлох бүтээгдэхүүний эрэлт, валютын орох урсгал сайжрахгүй тохиолдолд 2014–2015 онд төлбөрийн тэнцлийн хүндрэл үргэлжилж, гадаад валютын улсын нөөцөд учрах дарамт өсөж, эдийн засгийн эмзэг байдал нэмэгдэх, улмаар улсын зээлжих зэрэглэлд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй байхаар байна.  
Иймд Монголбанкнаас 2015 онд макро эдийн засгийн гадаад тэнцвэртэй байдлыг хангах орчинг бүрдүүлэхийн тулд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтлах бөгөөд ингэснээр дунд, урт хугацаанд экспортыг урамшуулах, дотоод үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг хамгаалах, хөрөнгө оруулалт болон төлбөрийн тэнцэл сайжрах зэрэг орчинг бүрдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг хамгаалах, эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой өсөлтөд дэмжлэг үзүүлнэ.
- Хэдийгээр ханш уян хатан тогтох боловч зах зээлд ханшийн огцом хэлбэлзэл валютын хомсдол үүсэж, гадаад валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэн тохиолдолд Монголбанк эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор валютын захад шаардлагатай тухай бүр оролцоно. Ингэснээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад ханшийн эрсдэлээ удирдан бууруулах, үйл ажиллагаагаа зохистойгоор төлөвлөх боломж олгож, зээлийн чанар муудах эрсдэлийг багасгах зэрэг нөлөөтэй байх болно.
- Цаашид ханшийн эрсдэлийг бууруулахын тулд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг макро зохистой бодлоготой уялдаатайгаар үр дүнтэй хэрэгжүүлнэ.

## Төгрөгийн ханш, 2014 оны эхний гүйцэтгэлээр

- 2013–2014 онд экспортынголлох бүртээгдэхүүний эрэлт, гадаад худалдааны нөхцөл муудаж, гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурснаар валютын орох урсгал эрс татарлаа. Үүнээс шалтгаалан эдийн засагт төлбөрийн тэнцлийн хүндрэл үүсэж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах дарамттай байв. Ийм орчинд Монголбанкнаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр уян хатан тогтох зарчмыг баримталж, гадаад худалдаанд шаардлагатай тохиргоо хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд удаан эдэлгээтэй хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт 2014 оны 7 дугаар сарын байдлаар 13 хувиар, түүний дотор автомашины импорт 21 хувиар, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, тавилгын импорт 6 хувиар тус тус буурлаа. Түүнчлэн экспортын болон дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар нэмэгдэх, дунд хугацаанд ажлын байрыг хамгаалах орчин бүрдэж байна.
- Монголбанк банкуудын гадаад зах зээлээс урт хугацаатай эх үүсвэр татах үйл ажиллагааг урамшуулах зорилгоор гурав болон түүнээс дээш жилийн хугацаатай бонд болон зээлийн эх үүсвэрийг заавал байлгах нөөцийн шаардлагаас чөлөөлж, нэг жилээс дээш хугацаатай гадаад валютын эх үүсвэрт урт хугацаатай своп хэлцэл хийх замаар ханшийн эрсдэлийг бууруулж байна. Мөн хувийн хэвшилд валютын ханш, зах зээлийн өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлээ удирдах боломжийг олгох зорилгоор ханшийн хэт хэлбэлзэл, валютын хомсдол үүссэн үед валютын захад тогтмол оролцож эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжиж ажиллаж байна.
- Монголбанк нь ханшийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зорилгоор зах зээлд оролцогчдын мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлд “Валютын зээл хүссэн иргэд, аж ахуйн нэгжүүдэд ханшийн эрсдэлийг санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан бууруулах зөвлөмж”, “Валютын зээл хүсэгчдэд зориулсан гарын авлага”-ыг банкуудаар дамжуулан тэдгээрийн харилцагчдад хүргүүлжээ.



### Тодруулга 3

- \* Төгрөгийн ханш уян хатан тогтох нь гадаад зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийн дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, экспортын болон дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжих замаар урт хугацааны өсөлтөд эерэгээр нөлөөлнө.
- \* Дэлхийн улс орнуудын сүүлийн 30 гаруй жилийн хандлагаас харахад гадаад зах зээлийн огцом өөрчлөлтийн үндэсний эдийн засагт учруулах сөрөг нөлөөлөл нь уян хатан, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмтэй орнуудыг ханшаа тогтмол түвшинд, тодорхой хязгаарт барьдаг орнуудтай харьцуулахад 1.5 дахин бага, нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт нь дунджаар 0.85 хувиар өндөр байсан байна.
- ✓ **Валютын ханшийг тодорхойлдог хүчин зүйлүүд:**
  - Эдийн засгийн гол үйл явдлууд / арга хэмжээнүүд/
  - Бүтээмжийн өөрчлөлт
  - Мөнгө, санхүүгийн талаарх төрийн бодлого
  - Үнэ, зээлийн хүү
  - Улс төр, сэтгэл зүйн хүчин зүйлүүд
  - Хүлээлт
  - Гадаад валютын эрэлт нийлүүлэлт
- ✓ **Валютын зах зээлийг зохицуулах талаар Засгийн газраас авч байгаа арга хэмжээ нь өөрийн үндэсний валютын ханшид девальваци болон ревальваци хийх чиглэлээр валютын зах зээлийг өдөөж байдаг.**
  - **Девальваци** гэдэг нь өөрийн орны валютын солилцооны ханшийг бууруулахад (сулруулах) чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг. Девальвацийн үед гадаадад худалдсан бараанд бага валют төлөх учраас тухайн орны бараа үйлчилгээний үнэ олон улсын зах зээл дээр хямдарч буйг илэрхийлнэ. Харин хилийн чанадаас худалдан авсан бараа үйлчилгээний үнэ нэмэгдэж, улмаар импорт хумигдахад нөлөөлж, дотоодын эрэлт буурдаг.
  - **Ревальваци** нь өөрийн орны валютын солилцооны ханшийг өсгөхөд (чангаруулах) чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг.
  - **Валютын интервенци** нь Төв банкгадаад валютын дээр гадаад валют худалдах, худалдан авах замаар валютын ханшид нөлөөлөх үйлдэл.



## Тодруулга 4

✓ **ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ** бол улс орны гадаад эдийн засгийн тухайн үеийн байдлыг илэрхийлдэг чухал ойлголт, өөрөөр хэлбэл, тухайн орны гадаад бусад улсуудтай хийсэн валютын гүйлгээ, урсгалын хэмжээг нэгтгэн илэрхийлдэг чухал статистик юм.

Төлбөрийн тэнцэл нь тухайн жилийн хугацаанд аль нэг орны хувь хүмүүс, пүүс компани, Засгийн газрын байгууллагуудаас бусад орнуудын мөн тийм хэмжээний субъектүүдтэй хийсэн гэрээ, хэлцлүүдийн нэгтгэсэн тэнцэл бөгөөд дараах 3 хэсгээс бүрддэг.

### I. Урсгал дансны тэнцэл (а+б+1.5.+1.6.)

1.1. Барааны экспорт

1.2. Барааны импорт

а. Гадаад худалдааны тэнцлийн үлдэгдэл(+–)  
ашигтай эсвэл алдагдалтай

1.3. Үйлчилгэний орлого

1.4. Үйлчилгээний зарлага

б. худалдаа үйлчилгээний тэнцлийн үлдэгдэл(+–)

1.5. Хөрөнгө оруулалтаас орох цэвэр орлого (+–)

– гадагш шилжүүлсэн ногдол ашиг

– хамтарсан үйлдвэрийн хийсэн дахин хөрөнгө оруулалтын хэмжээ

1.6. Урсгал шилжүүлгүүд /цэвэр/ [+–]

– Засгийн газрын шилжүүлгүүд

– Хувийн гуйвуулгууд

### II. Капиталын хөдөлгөөн буюу Санхүүгийн болон хөрөнгийн дансны тэнцэл

2.1. Санхүүгийн дансны тэнцэл

2.1.1. Урт ба дунд хугацааны хөрөнгө оруулалт

– Шууд хөрөнгө оруулалт

– Санхүүгийн хөрөнгө оруулалт

– Бусад хөрөнгө оруулалт / ашигласан зээл /

2.2. Хөрөнгийн дансны тэнцэл

2.2.1. Хөрөнгийн шилжүүлэг

2.2.2. Үйлдвэрлэдэггүй, санхүүгийн бусал актив

Санхүүгийн ба хөрөнгийн тэнцлийн үлдэгдэл (+ – )



## Тодруулга 4-ийн үргэлжлэл

Нийт төлбөрийн тэнцэл=Урсгал дансны тэнцэл  
(I)+санхүүгийн болон хөрөнгийн дансны тэнцэл(II)

### III Гадаад валютын албан нөөц

Төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдал болон гадаад гэнэтийн цочирлын сөрөг нөлөөллийг гадаад валютын албан нөөцийг ашиглах эсвэл ханшийн хэлбэлзлэлийг хүлээн зөвшөөрөх замаар даван туулж болдог.

✓ **Гадаад валютын цэвэр албан нөөцийг** гадаад актив /валютын харилцах, хадгаламж, кассын үлдэгдэл, мөнгөжсөн алт, гадаад орны Засгийн газрын үнэт цаас/ болон гадаад пассив /богино хугацаатай гадаад өр, гадаадын хөрөнгө/ –ын зөрүүгээр тооцдог.

+ **Гадаад актив** (валютын харилцах + хадгаламж + кассын үлдэгдэл+мөнгөжүүлсэн алт+гадаадын Засгийн газрын үнэт цаас)

- **Богино хугацаатай гадаад пассив** (гадаад өр+гадны хөрөнгө)

= **Гадаад валютын цэвэр албан нөөц**


✓ **Мөнгөжсөн алт нь** олборлосон алтыг хайлуулан цэвэршүүлж гадагш худалдахад бэлэн болгосныг хэлдэг бөгөөд гадаад валют гэж тооцогддог.

## 1.2.2. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ТАВИГДАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ





### 1.2.2а. БАНКУУДЫН ЭРСДЭЛ ДААХ ЧАДВАРЫН ДЭЭШЛЭЛТ 2015 ОНД





## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- Монголбанк банкуудад тавигдах ёстой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг олгож буй зээлийн өсөлттэй нь уялдуулан шат дараатайгаар нэмэгдүүлсний үр дүнд системийн төлбөрийн чадварын үзүүлэлтүүд тогтворжиж байгаа бөгөөд уг шаардлагуудыг цаашид ч эдийн засгийн нөхцөл байдал, банкуудын эрсдэлийн түвшинд үндэслэн өөрчлөх арга хэмжээг үргэлжлүүлж, банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ.
- Банкны зээл, бусад актив хөрөнгийг ангилах стандарт, тооцох аргачлалыг боловсронгуй болгох ажлыг үргэлжлүүлэх, активыг эрсдэлээр жигнэхдээ банкны ерөнхий эрсдэлийн түвшинд нийцүүлэх зэрэг хяналт шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах болно.
- Гадаад валютын ханшийн хэлбэлзэл болон бусад төрлийн эрсдэлүүдээс шалтгаалан зээлийн чанар муудахаас сэргийлэх, банкуудын зээлийн багц эдгээр эрсдэлд өртөмтгий эдийн засгийн салбаруудад голчлон төвлөрөх үзэгдлийг бууруулах зорилгоор банкуудын үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтын онцлогтой нь уялдсан эрсдэлийн удирдлагыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- Санхүүгийн нэгдэл хэлбэрээр зохион байгуулагдсан банкинд учрах эрсдэл нь дангаар үйл ажиллагаа явуулж буй банкнаас өндөр байдаг тул Монголбанкнаас бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран санхүүгийн нэгдэлд хийх хяналт шалгалтын аргачлалыг нэвтрүүлэх, шаардлагатай тохиолдолд банкны тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлнэ.
- Монголбанкны зээлийн мэдээллийн санд төвлөрөх мэдээллийн бүтцийг системийн болон гишүүн байгууллага тус бүрийн хувьд үүсэх зээлийн эрсдэлийг үнэлэх боломжтой байхаар өөрчилж, төвлөрүүлэх ажлыг эхлүүлнэ.

## **Банкны эрсдэл даах чадварыг дээшлүүлэх талаарх арга хэмжээ, 2014 оны 11 дүгээр сарын байдлаар**

- 2014 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар банкны салбарын 1 зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.1%, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 16.8% байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтүүдээс харгалзан 3.1 ба 4.8 нэгж хувиар тус тус өндөр байна. Үүнээс гадна банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байна. 2014 оны 8 дугаар сарын эцэст тус харьцаа 36.5%–д хүрсэн нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 11.5 нэгж хувиар өндөр байв. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа ийнхүү өндөр байхад банкуудын хөрвөх чадвар сайтай, богино хугацаат хөрөнгө оруулалтын тогтвортой өсөлт эерэгээр нөлөөлсөн.
- Банк нь гадаад валютын нээлттэй позици, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай. 2014 оны 8 дугаар сарын 31–ний өдрийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт хамгийн өндөр нэгж валютын хувьд -3.1 хувь, нийт валютын хувьд -3.8 хувьтай байгаа нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг хангаж байна.

Банкууд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг цаашид хэрхэн хангах, банкны үйл ажиллагаанаас болон нийт банкны систем, эдийн засгийн нөхцөл байдлаас үүсэж болзошгүй эрсдэлийг урьдчилан таамаглах зорилгоор Монголбанкнаас банкуудаар мэдрэмтгий байдлын шинжилгээг хийлгэж хэвшүүлэхээр ажиллаж байна. Энэ хүрээнд банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлох үүднээс 2014 оны 1 дүгээр улиралд зээлийн эрсдэл, том зээлдэгч, ханшийн эрсдэл, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар гэсэн 4 чиглэлд мэдрэмтгий байдлын шинжилгээг хийж, гарсан үр дүнг цаашид баримтлах бодлогод тусган ажиллаж байна. Түүнчлэн зээлийн эрсдэлийн, гадаад валютын ханшийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын мэдрэмтгий байдлын шинжилгээний загварыг олон улсын зөвлөлтэй хамтран боловсруулж, системийн бүх банкуудаар гүйцэтгүүлж, үр дүнг танилцуулсан бөгөөд цаашид шинжилгээний загварыг улам боловсронгуй болгохоор банкуудтай хамтран ажиллаж байна.



## Тодруулга 5

### ✓ **Динамик эрсдлийн сан:**

Динамик буюу Мөчлөг сөрсөн эрсдлийн сангийн тухай ойлголтыг анх Испанийн төв банкнаас 2000 онд танилцуулж, тухайн үед нүүрлээд байсан хэт их зээлийн өсөлтийг тогтворжуулах зорилгоор хэрэгжүүлж эхэлжээ. Тус улсад 1990–ээд оны дунд үеэс банкуудын хооронд хямд, бага хүүтэй зээлийн үйлчилгээгээр өрсөлдөх хандлага ихэссэнээр зээлийн хэмжээ огцом өсч, нийт зээл дэхь чанаргүй зээлийн хувийн жин буурч эхэлсэн бөгөөд чанаргүй зээлд харгалзах зээлийн эрсдэлийн сангийн хувийн жин нь бусад орнуудтай харьцуулахад хамгийн бага (1999 оны байдлаар) үзүүлэлттэйд тооцогдож байжээ. Тус улсын зээлийн эрсдэлийн сангийн хувь хэмжээ нь эдийн засгийн мөчлөгийг дагасан буюу эдийн засгийн өсөлтийн үед багасч, хямралын үед ихсэх шинжтэй болсноос гадна, өсөлтийн үед зээлийн эрсдэлийн бодит үнэлгээг бууруулах, эрсдэл өндөртэй төсөлд зээл олгох үзэгдэл ихэсч байжээ. Иймээс банкуудаас олгосон зээлийг тайлан тэнцэлд цэвэр дүнгээр тусгахдаа бодит эрсдлийн түвшинг бууруулж эсвэл өсгөж тусгах зөрчлийг арилгах, нуугдмал шинжтэй байсан эрсдлийн сангийн хэмжээг тайланд тусгуулах үүднээс динамик эрсдэлийн санг хэрэгжүүлж эхэлсэн байна. Испанийн төв банкнаас нэг талаас нуугдмал шинжтэй байгаа зээлийн эрсдлийг бодитоор тайлан тэнцэлд тусгах, нөгөө талаас зээлийн өсөлтөд хамаарах эрсдлийн сан байгуулалтын цаг хугацааны хоцрогдлыг арилгах зорилгоор Ерөнхий эрсдэлийн сангийн оновчтой хэмжээг тооцоолох статистик загварчлалыг боловсруулан хэрэгжүүлжээ. Динамик эрсдлийн санг байгуулснаар зээлийн хэт өндөр өсөлтийг хязгаарлах, хямралын бус цагт түүнээс хамгаалах нөөц санг бүрдүүлэх боломжийг олгоно гэж үзжээ. Нийт эрсдэлийн санг 1) Ерөнхий болон 2) Тусгай эрсдэлийн санд ангилсан байдаг.

Ерөнхий эрсдэлийн сангийн эдийн засгийн утга санаа нь тухайн зээлийн зориулалт, эдийн засгийн салбар нь нуугдмал эрсдлийг дагуулж байдаг тул уг эрсдлийг банкуудаас анх олгох зээлийн үнэлгээнд шингээх шаардлагатай гэсэн байр суурийг Испаний төв банк баримталж эхэлжээ.

Зээлийн зориулалт, эдийн засгийн салбар болон ерөнхий эрсдлийн түвшингээс хамаарч ерөнхий эрсдлийн сангийн тооцоог 6 төрлийн зээлийн ангиллын хувьд ялгавартайгаар тогтоодог байна.

**Тодруулга 5-ын үргэлжлэл****✓ Банкны өөрийн хөрөнгө:**

Банкны өөрийн хөрөнгөнд хувьцаат капитал(энгийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа гэх мэт), бусад өмч (нэмэлт хувьцаа, дахин үнэлгээний болон хандивын капитал), хуримтлагдсан ашиг, алдагдал, хоёрдогч өглөг, нийгмийн хөгжлийн сан орж тооцогддог.

**✓ Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд:**

Банк нь өөрийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдлийг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож ажилладаг.

- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт (өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаагаар тодорхойлогддог)
- Зээлийн төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа (Нийт өөрийн хөрөнгөнд нэг зээлдэгчийн авч болох зээлийн эзлэх хувиар тодорхойлогдоно)
- Үндсэн хөрөнгийн харьцаа
- Гадаад валютын ханшийн эрсдлийн зохистой харьцаа (Гадаад валютын актив, пассивын зөрүүгийн өөрийн хөрөнгөд эзлэх хувиар тодорхойлогдоно)
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа (түргэн борлогдох актив, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаагаар тодорхойлогдоно)

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
1	"Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ" = > 12%
2	"Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа" = > 6%
3	Зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлтүүд: А. Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <= 20% Б. Хувь нийлүүлэгч, банкны ажилтан, тэдгээрт холбогдох этгээдэд олгосон зээл: – Нийт ажилтнуудын хувьд өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <= 20% – Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгөнд эзлэх хувь <= 5%
4	Үндсэн хөрөнгийн харьцаа <= 8%
5	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой хэмжээ >= 25%

### **1.2.26. БАНКНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ 2015 ОНД**

З  
О  
Р  
И  
Л  
Т

2015

- ✓ Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлнэ.
- ✓ Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох эрх зүйн орчныг сайжруулах боломжийг судалж, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагатай хамтран үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- Монголбанкнаас хяналт шалгалтын чиглэлээр 2013–2019 онд хэрэгжүүлэх дунд хугацааны баримт бичигт тусгасан ажлын төлөвлөгөөний дагуу санхүүгийн байгууллагуудад хийх хяналт шалгалтын үндсэн зарчмууд өөрийн хөрөнгө болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдэд тавигдах нэгдсэн стандартыг шат дараатайгаар нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- Олон улсад түгээмэл мөрдөгддөг Базелийн цуврал стандартад заасан зохистой харьцаа, ерөнхий эрсдэлийг тооцох тоон үнэлгээний аргачлалыг нэвтрүүлж банкуудад мөрдүүлж ирсэн бөгөөд цаашид уг стандартад тусгасан тоон үнэлгээгээр үнэлэхэд хүндрэлтэй бусад төрлийн эрсдэлийг тооцох чанарын үнэлгээний аргачлалыг судалж, банкуудад мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- Банкуудад хэрэгжүүлж буй хяналт шалгалтын аргачлалыг банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэл, хохирлыг урьдчилан тооцох буюу эрсдэлд суурилсан аргачлалтай хослуулах замаар хяналт шалгалтын үйл ажиллагааны арга барилыг сайжруулна.
- Шинэчлэн боловсруулсан банкны зохистой засаглалын үндсэн зарчмуудын хэрэгжилтийг хангах, турших ажлыг эхлүүлж, үнэлгээний үнэн зөв байдлыг Монголбанкнаас банкуудад хийх хяналт шалгалтаар давхар баталгаажуулна.
- Банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйл ажиллагааны чиглэл, цар хүрээний хувьд төрөлжүүлэн олгох боломжийг судалж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг эхлүүлнэ. Ялангуяа, банк, түүний хараат болон охин компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шалгуур болон санхүүгийн үйл ажиллагааны хязгаарлалтыг нийтлэг болон төрөлжсөн банкны хувьд дотоодын санхүүгийн зах зээл дэх гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх боломжтой уялдуулан ялгаатайгаар тогтоох нөхцөлийг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран судалж, бүрдүүлэх ажлыг эхлүүлнэ.
- Монголбанкнаас гадаадын санхүүгийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, хяналт шалгалтын үр нөлөөтэй аргачлалыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгох, шалгалтад хамрагдаж буй байгууллагуудын талаар мэдээлэл солилцох, хянан шалгагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж харилцан туршлага солилцох чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.

## **Банкны хяналт шалгалт, 2014 оны 11 дүгээр сарын байдлаар**

- Монголбанкнаас 2014 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 9 банкинд иж бүрэн, 1 банкинд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан журам, заавруудын хүрээнд хийж илэрсэн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоох, шийтгэвэр ногдуулах зэрэг арга хэмжээг авч ажиллав.
- Олон улсын жишгээр хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан аргачлалаас эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжих хандлагатай байгаа тул банкуудын ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг урьтаж илрүүлэх, оновчтой тооцоолох, хяналт шалгалтын нөөц, чадавхыг эрсдэл өндөртэй байгаа үйл ажиллагааны чиглэлд түлхүү хуваарилах, улаар системийн эрсдэл үүсэх сөрөг үр дагаврын далайцыг бууруулах зориулалтын дэвшилтэт аргачлалыг нэвтрүүлэхэд Монголбанкны зүгээс онцгой анхааран ажиллаж байна.
- “Банкны хяналт шалгалтын дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги”-ийн төслийг боловсруулж, ойрын 5 жилд банкны хяналт шалгалтын хүрээнд хийгдэх онцлох арга хэмжээнүүдийг шат дараатайгаар авч хэрэгжүүлэхээр дунд хугацааны төлөвлөгөөнд тусгасантай холбогдуулан Базелийн цуврал стандартуудыг хэрэгжүүлэх ажлыг судалж байна.
- Банкуудад мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн багц материалыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэн боловсруулав.
- “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг Компанийн засаглалын хөгжлийн төв болон Азийн хөгжлийн банктай хамтран олон улсын стандартын үндсэн зарчмууд, “Монголын Компанийн засаглалын VII чуулган”-ы үеэр зохион байгуулагдсан “Банкны зохистой засаглалын зарчим” хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан санал, зөвлөмжид нийцүүлэн боловсрууллаа.



## Тодруулга 6

### ✓ Эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалт:

Санхүүгийн байгууллагуудад хийх хяналт шалгалтыг тухайн улсын холбогдох эрх бүхий байгууллага гардан хэрэгжүүлдэг бөгөөд хэлбэрийн хувьд газар дээрх болон зайны гэж ангилдаг бол аргачлалын хувьд гүйцэтгэлд суурилсан болон эрсдэлд суурилсан байдлаар хэрэгжүүлдэг. Газар дээрх шалгалт нь тухайн банкны өмнөх хугацаанд гаргасан алдааг нээн илрүүлэх буюу гүйцэтгэлд суурилсан шинж чанартай байх бол зайнаас тавих хяналт шалгалт нь гүйцэтгэлд суурилсан аргачлалаас гадна банкны ирээдүйд хүлээж болзошгүй эрсдэлийг нээн илрүүлэхэд чиглэгдсэн байна. Түүнчлэн дээрх хоёр нэгж нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тусгай боловсруулсан журмын дагуу хамтран ажиллах, мэдээлэл солилцох үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

Өмнөх хугацаанд дэлхийн улс орнууд голчлон гүйцэтгэлд суурилсан аргачлалыг ашиглан хяналт шалгалтын үүргээ гүйцэтгэж ирсэн боловч байгууллагуудад нэгэнт бий болсон алдагдал, хохирлыг нөхөж илрүүлдэг шинж чанар нь дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралаас сэргийлэх, төрд учруулах хохирлыг бууруулахад хангалттай нөлөө үзүүлж чадаагүй. Энэхүү дутагдалтай талыг арилгаж, хяналт шалгалтын байгууллагуудын хараат бус байдал, эрсдэлээс сэргийлэх чадамжийг сайжруулах зорилгоор дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын санхүүгийн хяналтын байгууллагууд болон Базелийн банкны хяналт шалгалтын хорооноос эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг шинээр нэвтрүүлэх шаардлагатай талаар онцолж, эрх бүхий байгууллагуудыг энэ аргачлалыг ашиглаж хэвшихийг уриалж, тодорхой стандарт, зөвлөмжүүдийг гаргажээ.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг оновчтой нэвтрүүлснээр хяналтын байгууллагуудын хязгаарлагдмал санхүүжилт, ажиллах хүчний нөөцийг нийт хяналтад хамрагдаж буй санхүүгийн байгууллагуудаас төлбөрийн чадвар муудах магадлал өндөр, санхүүгийн системд үзүүлэх нөлөөлөл ихтэй байгууллагууд, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, салбар нэгжүүдэд илүүтэйгээр хуваарилах, хяналтын үйл ажиллагааг голчлон хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, эрсдэл өндөртэй байгаа хэсэгт илүү анхаарал хандуулснаар цаашид үүсэж болзошгүй системийн шинж чанартай эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар алдагдаж системийн бусад



## Тодруулга 6-ын үргэлжлэл

хэсэгт тархаахаас өмнө яаралтай зохицуулалтын арга хэмжээг авч санхүүгийн тогтвортой байдлыг хангах боломжтой.

Түүнчлэн өмнө нь эрх бүхий байгууллагуудын зүгээс тус тусдаа бие даан хэрэгжүүлж ирсэн макро бодлогуудыг хослуулах замаар бодлогын оновчтой хэрэгслүүдийг ашиглаж санхүүгийн тогтвортой байдлыг хангах ойлголтод тулгуурлан хэрэгжүүлж буй макро зохистой бодлого нь мөн эрсдэлд суурилсан хяналт шалгалтын ажиллагаатай салшгүй холбоотой.

Монголбанкнаас энэ хүрээнд банкны хяналт шалгалтын чиглэлээр 2013–2019 онд хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичгийг боловсруулсан бөгөөд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг гүйцэтгэлд суурилсан хяналтын аргачлалтай оновчтойгоор хослуулах замаар банкны хяналт шалгалтын үйл ажиллагааг олон улсад мөрдөгдөх үр нөлөөтэй хяналт шалгалтын үндсэн зарчмуудтай нийцүүлэн хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.




### **1.2.3. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ТАВИГДАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

З  
О  
Р  
И  
Л  
Т

2015

- ✓ Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр ажиллана.
- ✓ Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.
- ✓ Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална. Энэ хүрээнд инфляцийн төлөв байдлын илтгэлийг улирал бүр, санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.
- ✓ Санхүүгийн зах зээлд экспортын болон давхар даатгалын оновчтой тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлнэ.

### 1.2.3а. ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМИЙН ХӨГЖИЛ 2015 ОНД



#### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний дэд бүтцийг ашиглаж, банкуудын дэвшилтэт технологид суурилсан шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгон, аливаа төлбөрийн сувгаар төлбөр гүйцэтгэх боломжоор хангах замаар банкны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Тухайлбал, төрийн үйлчилгээний байгууллагуудын цахим нэхэмжлэлийн нэгдсэн санг байгуулж, татвар торгууль, даатгалын хураамжийг аль ч банкны салбар, интернет, мобайл банкны үйлчилгээг ашиглаж төлөх боломжийг бүрдүүлнэ.



### **Төлбөр тооцооны систем, 2014 оны 11 дүгээр сарын байдлаар**


- Монголбанк их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, бага дүнтэй төлбөрийн систем болон үнэт цаасны төлбөр тооцооны найдвартай, тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. “Банксүлжээ” систем нь 2014 оны эхнээс 8 дугаар сарын 31-ний хугацаанд нийт 37.8 их наяд төгрөгийн дүнтэй 790.9 мянган ширхэг их дүнтэй гүйлгээг, Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) нь нийт 1 их наяд төгрөгийн дүнтэй 19.4 сая ширхэг картын гүйлгээ, 488 тэрбум төгрөгийн дүнтэй 3.9 сая ширхэг бага дүнтэй гүйлгээг тус тус амжилттай дамжуулсан байна. Мөн хугацаанд банк хоорондын их, бага дүнтэй төлбөр тооцооны систем болон картын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явагдав.
- “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээг 24/7 хуваариар онлайн горимд дамжуулах ажлын хүрээнд 12 оролцогчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийлээ. Шалгалтаар нийт оролцогчид “Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог гар ажиллагаатай хийсэн, шалгалт хийсэн 1 өдрийн саатлын дансанд 354.7 сая төгрөгийн 2688 гүйлгээг саатуулсан болохыг шалгаж тогтоов. Мөн дээрх шалгалтын явцад зөвхөн ажлын өдөр 9–17 цагийн хооронд бага дүнтэй гүйлгээг илгээж, хүлээн авдаг гэх буруу ойлголт бүх шатанд байсан, үүний улмаас бага дүнтэй гүйлгээний тлаар буруу мэдээлэл гарч байсныг илрүүлээ.



## Тодруулга 7

- ✓ Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өсөлттэй холбоотойгоор төлбөр тооцооны системээр дамжин хийгдэж буй банк хоорондын гүйлгээний тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна.
- ✓ Төлбөрийн системийн оролцогч хооронд 2014 оны эхний хагас жилийн байдлаар 28.3 их наяд төгрөгийн 9.6 сая ширхэг гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс гүйлгээний дүн 12.8 хувиар буюу 6 их наяд төгрөгөөр, гүйлгээний тоо 30 хувиар буюу 1.1 сая ширхгээр өссөн үзүүлэлттэй байна.
- ✓ Төлбөрийн картаар 2014 оны эхний хагаст нийт 717.7 тэрбум төгрөгийн, 14.4 сая ширхэг гүйлгээ хийгдэж, өмнөх оны мөн үеийнхээс картын гүйлгээний дүн 206.0 тэрбум төгрөг буюу 40.3 хувиар, картын гүйлгээний тоо 3.7 сая ширхэг буюу 34.6 хувиар тус тус өсчээ.

### 1.2.36 . БАНКНЫ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ, ХАРИЛЦАГЧДЫН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ



#### ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг олон талт байдлаар иргэдэд хүргэх, гарах эрсдэлийг бууруулах, санхүүгийн үйлчилгээний эрэлтийг тодорхойлж, түүнтэй уялдуулж нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн оролцоог тодорхой болгох талаар судалгаа хийж, хэрэгжүүлэх боломжийг тодорхойлно.
- Иргэдийн санхүүгийн салбарын талаарх мэдлэгийг дээшлүүлж, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах чадварыг бүрдүүлэх, санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн салбарт итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх чиглэлд хийгдэж буй арга хэмжээг үргэлжлүүлнэ. Энэ хүрээнд төр захиргааны байгууллагуудтай хамтран иргэдийн боловсролын түвшинтэй уялдсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, үргэлжлүүлж хэрэгжүүлнэ.



## Тодруулга 8

- ✓ **Банкны эрхлэх үйл ажиллагаа**
- мөнгөн хадгаламж
  - зээл
  - төлбөр тооцооны үйлчилгээ
  - өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах
  - гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах
  - үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах
  - үнэт зүйл хадгалах
  - гадаад төлбөр тооцоо хийх
  - үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах
  - санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа
  - зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах
  - санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
  - итгэлцлийн үйлчилгээ
  - даатгалын зуучлагч
  - андеррайтерийн үйлчилгээ
  - кастодиан
  - факторингийн үйлчилгээ
  - харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ

- ✓ **Санхүүгийн түрээс:**
- Санхүүгийн түрээс гэж түрээслүүлэгч нь түрээслэгчийн захиалгын дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл зэрэг ашиглалтын явцад үндсэн шинж чанараа алддаггүй, үндсэн хөрөнгөд хамаарах биет эд хөрөнгийг өөрөө үйлдвэрлэх буюу гуравдагч этгээдээр үйлдвэрлүүлэх, эсхүл түүнээс худалдан авч гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд, төлбөртэйгээр түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад шилжүүлэх, түрээслэгч нь тогтмол хугацаанд түрээсийн төлбөр төлөхийг ойлгох бөгөөд үүнийг “анхдагч түрээс” гэдэг.

## Тодруулга 8-ын үргэлжлэл

### ✓ **Итгэлцлийн үйлчилгээ:**

Итгэлцлийн үйлчилгээ гэж итгэмжлэгчийн бэлэн мөнгө, зээл, бусад активыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцож байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр итгэмжлэгдэгчээс гэрээнд заасан хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг хэлдэг.

### ✓ **Даатгалын зуучлагч:**

Даатгалын зуучлалын үйлчилгээ гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий үйл ажиллагааг хэлдэг.

### ✓ **Андеррайтерын үйлчилгээ:**

Үнэт цаасыг нь бүхэлд нь буюу зарим хэсгийг тодорхой үнээр авахыг баталгаажуулсаны үндсэн дээр харилцагчийнхаа үнэт цаасыг гаргаж анхлан байршуулах талаарх хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа юм.

### ✓ **Факторингийн үйлчилгээ:**

Зээлдүүлэгч буюу үүрэг гүйцэтгэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхээ гуравдагч этгээдэд бүхэлд нь шилжүүлэх, энэхүү эрхийг хүлээн авагч нь эрхээ хэрэгжүүлэх болон үүсэн гарах үр дагаварыг бүрэн хариуцах үйл ажиллагаа юм.

### ✓ **Кастодиан:**

Гэрээний дагуу эд, үнэт зүйлс хадгалах, орлого цуглуулах, өмчлөгчийн үүрэг болгосноор эд, үнэт зүйлстэй холбогдсон үйл ажиллагаа явуулах үйлчилгээ юм.



### **1.2.3в. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ИЛ ТОД БАЙДАЛ 2015 ОНД**

З  
О  
Р  
И  
Л  
Т

2015

✓ Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална. Энэ хүрээнд инфляцийн төлөв байдлын илтгэлийг улирал бүр, санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ



- 2015 онд мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгохын тулд Төв банкны тухай хуульд өөрчлөлт оруулах, Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд бодлогын хэрэгжилтийг олон нийтэд тайлбарлан таниулах, мөнгөний бодлого, макро эдийн засгийн талаарх иргэдийн эдийн засгийн мэдлэгийг ахиулахад үргэлжлүүлэн анхаарна.
- Монголбанкны бодлого, үйл ажиллагааг олон нийтэд хүргэхэд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажиллахын зэрэгцээ ард иргэдэд нам, тогтвортой инфляцийн ач холбогдлыг тайлбарлан таниулах, их дээд сургуулийн оюутан, сурагчдад мөнгөний бодлогын талаар сургалт хийж мэдээлэл өгөх зэрэг ажлуудыг цаашид үргэлжлүүлнэ..
- “Мөнгөний бодлогын мэдэгдэл”-ийн агуулгад анхаарч, мөнгөний бодлогын мэдэгдэлд Төв банк юухийж байгаагаа, ямар шийдвэрийг юуны учир гаргаснаа тайлбарлаад зогсохгүй бодлогын боломжит хувилбарууд дотроос чухам алийг нь ямар үндэслэлээр сонгосон, энэ нь инфляцийн зорьсон түвшинд хүрэх зорилготой хэрхэн уялдаж байгаа талаар илүү нээлттэй тайлагнадаг болохоор төлөвлөж байна.
- Монголбанк цаашид банкны төдийгүй, иргэдийн бизнесийн төлөөлөлтэй ажил хэргийн уулзалт хийх, эргэх холбоог сайжруулах ажлыг хийж, өөрийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хадгалан, Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

### **Ил тод байдал, хариуцлагын түвшин /2014 оны байдлаар/**

- Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл /МБЗ/ нь 14 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд Монголбанкнаас 7 гишүүн, төрийн болон хувийн бйгууллага, их сургуулийн багш, судлаачдыг төлөөлсөн хараат бус 7 гишүүн ажиллаж байна. Тус зөвлөл нь мөнгөний бодлогын саналыг батлагдсан журмын дагуу 2–3 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг тал бүрээс нь авч үзэн мэтгэлцээний үр дүнд бодлогын шийдвэр гаргадаг ба шийдвэрийг хэвлэлийн хурал, мөнгөний бодлогын мэдэгдлээр олон нийтэд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж гарсан шийдвэрийн үндэслэлийг нь тайлбарлан, хуралдааны тэмдэглэлийг цахим хуудаст байршуулж байна.
- Олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор Монголбанкнаас мөнгөний бодлогын үндсэн зорилт, чиглэл, үйл ажиллагаа, ил тод байдал, бодлогын харилцан уялдаа, макро эдийн засаг, санхүүгийн суурь ойлголт зэрэг өргөн хүрээтэй асуудлаар олон нийт болон хэвлэл, мэдээллийн ажилтнуудад зориулсан цуврал сургалт, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж, хэрэгжүүлж буй бодлоготой холбоотой бүхий л эрх зүйн баримт бичиг, журам, заавар,с удалгааны ажил, тайлан, мэдээлэл, статистик мэдээ, хэвлэмэл бүтээгдэхүүнийг Монголбанкны цахим хуудаст байршуулан нийтэд танилцуулж ажиллав.



## Тодруулга 9

Өнөөдөр дэлхийн ихэнх Төв банк үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх нөлөөтэй хэмээн үздэг болсон байна. Үйл ажиллагааны ил тод байдал нь Төв банкны бодлогын хэрэгжилт, богино хугацааны зорилтууд, макро эдийн засгийн гэнэтийн /хүлээгдээгүй/ цочирлын нөлөө зэрэг асуудлыг хамардаг.

Эдийн засгийн нөхцөл байдлыг тогтмол үнэлэн, бодлогын арга хэмжээнүүдээ тайлбарлах нь мөнгөний бодлогын үндэслэл, хариу үйлдлийг зөв ойлгох боломж олгох төдийгүй Монголбанкны мөнгөний бодлогыг дунд хугацаанд таамаглагдахуйц болгох ач холбогдолтой. Энэ нь эргээд зах зээлийн хүлээлтийг зөв зохистой, үр ашигтай бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна.

## II ХЭСЭГ

---

### АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД





## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 69

Төрийн ордон,  
Улаанбаатар хот

### **Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.
2. Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1/Засгийн газрын болон түүний баталгаатай гадаад өрийн эргэн төлөлттэй уялдсан төсвийн зохистой бодлого хэрэгжүүлж, төсвийн тогтвортой байдлыг хангах;

2/Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний цогц төлөвлөгөөг 2015 оны 1 дүгээр улиралд багтаан боловсруулж хэрэгжүүлэх, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэн төлбөрийн тэнцэл, улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах;

3/нийлүүлэлтийн гаралтай инфляцийг аймаг, нийслэлийн түвшинд нам, тогтвортой байлгах арга хэмжээ авах;

4/Монгол Улсын төсвийн төсөл, Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл боловсруулахад ашиглах төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн төсөөллийг тогтсон аргачлал, эх сурвалжид үндэслэн боловсруулах;

5/улсын гадаад өр, түүний эргэн төлөлтийн гадаад валютын ханшийн эрсдэлийг бууруулж, эрсдэлээс хамгаалах механизм бий болгох.

3. Доор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай:

1/ эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурийг бэхжүүлэх, дотоодын хуримтлалыг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор нийгмийн даатгал, тэтгэврийн сангийн тогтолцооны шинэчлэлийг эрчимжүүлэх, баялгийн сангийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын сангуудыг бий болгох, тэдгээрийг үе шаттай хөрөнгөжүүлэх;

2/ 2015-2017 онд санхүүгийн салбарт зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх зорилгоор “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолд заасан арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

3/ Монголбанк, Засгийн газар хооронд макро эдийн засгийн нэгдсэн мэдээллийн тогтолцоог бий болгох, макро зохистой бодлого хэрэгжүүлэх хүрээнд төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоог сайжруулах.

4.Төгрөгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжих, банкны салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ авахыг Монголбанк /Н.Золжаргал/-нд даалгасугай.

5.Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бий болгож, хөтөлбөрөөс



үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай.

6.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд тус тус даалгасугай.

7.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



Монгол Улсын Их Хурлын 2014 оны  
69 дүгээр тогтоолын хавсралт

## **ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2015 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Мөнгөний бодлогын үндсэн зорилт нь эдийн засгийн гадаад тэнцвэрийг хангах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, эдийн засаг дунд, урт хугацаанд тэнцвэртэй бөгөөд тогтвортой өсөх орчныг бүрдүүлэхэд чиглэнэ.

### **1.Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:**

1.1.Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг 2015 оны эцэст 7 хувьд, 2016-2017 онд энэ түвшинд тогтворжуулах бодлогын оновчтой хувилбарыг сонгон иргэдийн бодит орлогыг хамгаалж, эдийн засаг тогтвортой өсөх нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжихүйц уян хатан тогтож, улмаар дунд хугацаанд дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ажлын байрыг хамгаалахтай нийцтэй байх зарчим баримтална.

### **2.Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд:**

2.1.Банкуудын төлбөрийн чадварыг хадгалах хүрээнд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх замаар системийн болзошгүй эрсдэлээс хамгаалах чадварыг нэмэгдүүлж, санхүүгийн салбарын дархлааг сайжруулна.

2.2.Олон улсад мөрдөгдөж байгаа хяналт шалгалтын зарчим, зохицуулалтын арга хэрэгслийг банкны салбарын үйл ажиллагааны онцлогтой уялдуулан эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг үргэлжлүүлнэ.

2.3.Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн олгох эрх зүйн орчныг сайжруулах боломжийг судалж, дотоод, гадаадын эрх бүхий байгууллагатай хамтран үр нөлөөтэй хяналт шалгалтыг боловсронгуй болгох чиглэлд ажиллана.

### **3. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, түүний институцийг бэхжүүлэх хүрээнд:**

3.1. Монгол Улсын төлбөр тооцооны системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж, дэвшилтэт технологид суурилсан банкны шинэлэг үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй болгох чиглэлээр ажиллана.

3.2. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.

3.3. Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааг улам боловсронгуй болгон, мөнгөний бодлогын үндсэн зорилт, хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах ажлыг үргэлжлүүлж, Төв банкны нээлттэй, ил тод байдлыг хадгална. Энэ хүрээнд инфляцийн төлөв байдлын илтгэлийг улирал бүр, санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

3.4. Санхүүгийн зах зээлд экспортын болон давхар даатгалын оновчтой тогтолцоог бий болгох ажлыг эхлүүлнэ.

3.5. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламжийг мөнгөн хадгаламжийн даатгалд хамруулах бэлтгэл ажлыг хангана.

3.6. Тогтвортой санхүүжилтийн санаачилгыг дэмжиж ажиллана.



Мөнгөний үзүүлэлтүүд /2008-2015/*															
Мөнгөний гайм											(өвөрөөр заагаагүй бол тэрбум төгрөг)				
	2008	2009	2010	2011	2012	2013				2014				2015	
	Q4	Q4	Q4	Q4	Q4	Q1	Q2	Q3	Q4	Q1	Q2	Aug	Q4	Q4	
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц				Гүйц	Төс			Төс	
M2 мөнгө	2270	2880	4680	6412	7617	7301	8004	8482	9451	9949	10107	10136	10352	9946	11090
M1 мөнгө	647	651	1158	1741	1835	1589	2027	2017	2083	1737	1862	1875	1871	1798	2005
Банкаас гадуурх мөнгө	329	285	388	517	603	483	600	597	582	550	571	616	629	604	674
Харилцах Т	319	366	769	1224	1232	1107	1426	1419	1501	1188	1291	1259	1242	1193	1331
Бараг мөнгө	1623	2229	3522	4671	5782	5711	5977	6465	7368	8212	8245	8261	8481	8148	9085
Дотоод цэвэр актив	1587	1347	1941	3345	3215	3370	5224	6547	8517	9460	10792	11038	10937	12070	12684
Дотоодын цэвэр зээл	2062	1938	2430	4271	3949	4380	6075	8089	9921	11394	12698	12881	12766	13284	14135
ЗГ-ын цэвэр зээл	-574	-717	-835	-1370	-3040	-3011	-2533	-2270	-1048	-646	-257	-314	-386	51	51
Банк бусгаас авах авлага	2636	2655	3265	5641	6988	7391	8608	10358	10969	12040	12954	13195	13152	13234	14085
Үүдээс зээл				5641	6988	7391	8608	10153	10764	11381	12302	12385	12342	12239	13260
Үүдээс хөтөлбөрийн зээл				0	193	251	699	1346	1601	1782	1997	1921	1991	1618	1256
Бусад зээл				0	6796	7140	7909	8808	9163	9599	10305	10417	10569	10838	12013
Бусад санхүүгийн байгууллагаас авах авлага (МИК, ХДК, МУХБ-аас авах авлага)								205	205	659	652	810	810	995	825
Бусад цэвэр зүйл	-475	-591	-489	-926	-733	-1009	-851	-1542	-1404	-1934	-1906	-1843	-1830	-1214	-1451
<b>Төв банк</b>															
Ноёд мөнгө	634	733	945	1660	2166	2468	3509	2943	3335	3127	2882	2815	2932	2965	2953
Дотоод цэвэр актив	-171	-805	-1584	-1384	-2999	-2318	-281	21	1394	1550	2397	2623	2417	2759	2901
ЗГ-ын цэвэр зээл	-183	-265	-492	-714	-2774	-2917	-2728	-2418	-1685	-1250	-853	-821	-663	-505	-600
Хөгжлийн банкны цэвэр зээл	0	0	0	0	-32	-1	0	-1	0	-1	-2	161	-47	-47	-9
Банкинд олгосон зээл	243	198	131	342	401	1215	2883	3592	4297	3020	2914	2638	2708	2406	2143
Үндэс тогтворжуулах хөтөлбөр	0	0	0	0	205	254	888	1002	1229	1186	1355	1107	1137	934	572
Ипотекийн зээл	0	0	0	0	0	0	0	1410	1541	1268	1204	1287	1327	1157	1157
Монголбанкнаас банкуудад байршуулсан хадгаламж	0	0	0	0	0	850	900	900	405	150	100	0	0	0	0
Бусад	0	0	0	0	196	111	103	280	1122	417	255	245	245	315	415
МИК бонд, ХДК-ын зээл	0	0	0	0	0	0	0	205	205	659	652	640	640	825	825
Хасах нь: ТБҮЦ	120	393	1101	879	752	743	668	1543	1627	1103	854	576	794	617	156
Бусад цэвэр зүйл	-112	-346	-122	-133	158	129	233	187	205	224	540	580	573	698	698
<b>Мөнгөний үзүүлэлтүүд:</b>															
M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	34.6	26.9	62.5	37.0	18.8	19.6	13.5	19.3	24.1	36.3	26.3	20.5	22.1	5.2	11.5
Ноёд мөнгөний жилийн өөрчлөлт (%)	19.7	15.7	29.0	75.5	30.5	36.0	53.8	22.4	54.0	26.7	-17.9	8.2	-0.4	-11.1	-0.4
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	3.58	3.93	4.95	3.86	3.52	2.96	2.28	2.88	2.83	3.18	3.51	3.60	3.53	3.35	3.76
Эзэлийн жилийн өөрчлөлт (%)	41.7	0.7	23.0	72.8	23.9	27.8	36.2	50.8	57.0	62.9	50.5	26.1	27.0	20.6	6.4
Хөтөлбөрөөс бусад эзэлийн өсөлт (%)					20.5	23.5	25.2	28.3	34.8	34.4	30.3	21.0	17.3	18.3	10.8
Эзэл/M2 мөнгө	1.16	0.00	0.00	0.88	0.92	1.01	1.08	1.20	1.14	1.14	1.22	1.22	1.19	1.23	1.20
Эзэл/ДНБ	0.40	0.40	0.39	0.51	0.42	0.43	0.49	0.56	0.57	0.61	0.88	0.83	0.77	0.62	0.57
Мөнгөний эргэлтийн хурд	2.89	2.63	2.39	1.97	2.46	2.41	2.40	2.42	2.36	2.25	1.56	1.63	1.62	2.13	2.23
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш (хугацааны эцэст)	1268	1443	1256	1396	1392	1410	1444	1646	1659	1783	1826	1818			
Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	6556	6591	8415	11088	16688	17810	17557	18490	19118	19741	14660	15813	17069	21259	24746
Болит ДНБ-ий жилийн өсөлт (%)	8.9	-1.3	6.4	17.5	12.3	10.3	9.8	13.7	11.6	11.6	10.1		5.3	3.3	6.1
Уул уурхайн ДНБ	-1.6	5.8	3.6	7.3	8.4	7.4	5.3	15.1	19.4	22.9	24.0		16.3	10.9	8.1
Уул уурхайн бус ДНБ	11.3	-2.7	7.0	19.7	13.3	11.0	10.9	13.4	9.8	9.0	6.9		2.6	1.3	5.4
Жилийн инфляци (%)	23.2	1.9	14.3	9.4	14.2	8.3	6.5	6.9	11.2	11.9	15.1	15.4	15.4	13.4	10.5

\*Төсөөлөл нь бодлогын өөрчлөлт тусгаагүйг суурь төсөөлөл болно.

Тэмдэглэл: Зах зээлийн хүлээлтэд сөрөгөөр нөлөөлж болзошгүй зарим үзүүлэлтийг хүснэгтэд тусгаагүй болно.

Эх сурвалж: Монголбанк



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ - Азийн хөгжлийн Банк

М1 - Мөнгө 1

М2 - Мөнгө 2

М3 - Мөнгө 3

МБЗ - Мөнгөний бодлогын зөвлөл

ДНБ - Дотоодын нийт бүтээгдэхүүн

УИХ - Улсын Их Хурал

ХҮИ - Хэрэглээний үнийн индекс

Т карт - төгрөгийн карт



**© Энэхүү товхимолыг үнэгүй тарааж байгаа бөгөөд ашиг олох зорилгоор олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.**

**Боловсруулсан: Ж.БАТСАЙХАН**  
**Редакторласан: С.БОЛД**

**Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:**  
**Д.ЦЭЦЭГМАА**  
**Б.УУГАНЦЭЦЭГ**  
**Т.УРАНЧИМЭГ**

**ЭЗБХ-ны Ажлын алба**

**Утас: 267451, 260749**

**Факс: 327016**





